



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

ЕГ шифр: ХТСИ_05/24

МАРШАЛЫН ГҮҮРЭЭС ЦЕНТРАЛ ТАУРЫН УУЛЗВАР ХҮРТЛЭХ 7.1 КМ
ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТАЛБАЙН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН
ЗУРАГ ТӨСӨЛ
/ОЛИМП, ИХ МОНГОЛ УЛСЫН ГУДАМЖ ОРЧМЫН
ЯВГАН ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ/

БОТЬ IV

ЗАХИАЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



В.МЯГМАР

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ
ОНӨААТҮГ-Н ДАРГА

Р.АМАРТҮВШИН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

А.БАТТӨМӨР


УЛААНБААТАР ХОТ 2024 ОН

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

ЯВГАН ЗАМЫН АЖЛЫН ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Д/а	НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ	Зургийн марк	Формат
1	ЗУРАВДУГААР ХЭСЭГ	...	A3
2	6. ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ	...	A3
3	1.1 Байршилын схем	B1.1/ХУ-1	A3
4	1.2 Орчны тойм	B1.2/ХУ-1	A3
5	1.3 Замын дэвсгэр зураг, Дагуу огтлол	B1.3/ХУ-24	A3
6	1.4 Нэг маягийн хөндлөн огтлол хучилтын хийц	B1.4/ХУ-6	A3
	1.5 Налуу замын хэсэглэл ба хөтөч хавтангийн төлөвлөлт	B1.5/ХУ-3	A3
7	1.6 Хөндлөн огтлолууд	B1.6/ХУ-98	A3
8	1.7 Трассын координат	B1.7/ХУ-6	A3
9	1.8 Нэгдсэн ажлын тоо хэмжээ	B1.8/ХУ-32	A3
10	1.9 Тайлбар дичиг, Техникийн шаардлага	B1.9/ХУ-17	A3

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ЗТ19-507/10	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ					
	ЭТСХТ-ийн дарга	<i>C. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ЗУРГИЙН ЖАГСААЛТ	Үе шат: A/3	
	Архитектор	<i>Н. Мөнхзул</i>	Н. Мөнхзул	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: M1:100	Огноо: 2024.05
	Гүйцэтгэсэн	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ Шифр:	Зургийн дугаар: 1	Хуудас: 4

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

3
VI

АЖЛЫН ДААЛГАВАР


БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
С. БАЯРСАЙХАН

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР**
Дугаар: 240104049

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 75 дугаар тушаалаар баталсан "Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах үйл ажиллагааны журам" - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн А/510 дугаар захирамж. - 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн МЗХ/2024/00-081 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар.
2	Байршил	1. Энэтхэвний өргөн чөлөө, Москвагийн гудамж 2. Олимпын гудамж, Их монгол улсын гудамж 3. Чингисийн өргөн чөлөө 4. Их тойруу 5. Бага тойруу 6. Төв талбай орчим
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн төсвийн хөрөнгө
4	Авто замын техникийн ангилаг замын зэрэг	Явган зам
5	Газрын бартаалаг, төлөвшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төлөвшлийг БНБД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2024 он
8	Зураг төслийн байгууллага	Хот төлөвлөлт судалгааны институт ОНЗААТҮГ
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн Замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Авто зам, замын байгууламжийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл 3. Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт) 4. Техникийн шаардлага 5. Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв 6. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв

11. Онцгой нөхцөл:

- Авто зам замын байгууламжийн зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗБНБД 22-004-2016, "Хот төсвийн төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6058-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 56 828 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага", Хот, сууриньн гудамж, зам төлөвлөлт БНБД21-08-10, Зураг, төсвийг холбогдох норм, хуулийн дэгуу магадлалаар баталгаажуулах.
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/456 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901:2020, UCS 0902:2020, UCS 0903:2020, UCS 001-02-2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, 1405C:2020-г тус тус мөрдөх.
- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цаг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох.
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зураг төслийг боловсруулах.
- Нийслэлийн нийтийн тээврийн нэгдүгээр эгнээний замын зураг төсөлтэй уялдуулах.
- Нийслэлийн Засаг даргын А/900 дугаар захирамжийн хүрээнд боловсруулагдсан Түгжрэлийг бууруулахад чиглэсэн шулуун коридор бүхий дугуйн болон явган замын зураг төслийн трасс давхацсан хэсгийн техникийн зураг төслийг сайжруулж шинэчлэх.
- Захиалагчийн хүсэлтээр хөрөнгө оруулалтын хуваарийн ажлын тоо хэмжээг гудамж бүрээр салгаж боловсруулах жишээ нь: Баянбүрдийн тойргоос Зуун айл худалдааны төв хүртэлх явган замын зураг төсвийг тусад нь салгаж боловсруулах.
- Гудамж замын төлөвлөлтийн талаар танилцуулга, мэдээллийг тайлбар бичигт тусгах, захиалагч байгууллагад урьдчилан танилцуулах.
- Явган замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, унадаг дугуйн зам /төсөлөөр/, уулаар төлөвлөлт, орц гарц ногоон байгууламж, тусгаарлах зураас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрээр төсөллөх, план зурагт инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж, орчны харагдах нөхцөл байдлаар уялдуулж төлөвлөх.
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, айлууд руу орох орц гарцын шийдлийг оноогчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх.
- Гадаргуугийн ус зайлуулахыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.
- Явган замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах.

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ 3Т19-507/10	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТХХТ-ийн дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	С. Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Гүйцэтгэсэн	МЭРГЭЭНИЙН АНХБЭЭР НЭГДСЭН АНХБЭЭР С. Анхбаяр	Масштаб: М1:100
	Шалгасан	С. Анхбаяр	ТГ Шифр: 1
			Ye шат: А/3
			Огноо: 2024.05
			Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

АЖЛЫН ДААЛГАВАР

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах.
- Одоо байгаа дугуйн зам, явган замын геометр хэмжээс, төлөвлөлтийн огтлолцож буй уулзвар, гарц, болон орчны нөхцөлтэй уялдуулж, хөдөлгөөн зохион байгуулалтын болон бусад техникийн шийдлийг оновчтойгоор төлөвлөх.
- Явган замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн ад зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар төлөвлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.
- Явган замын гэрэлтүүлгийн төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж гэрэлдлийн маягт баглах/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000 босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтээц	1:20
- Явган хүний замын төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, ГУББГ ОНӨААТҮГ, Улаанбаатар дугааны сүлжээ ТӨХК-тэй тус тус зөвшилцсэний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал авсан зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг Нийслэлийн авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "хотын замын мэдээллийн сан"-д оруулах, баталгаажуулах /хаасралтын дагуу боловсруулах/.
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалт, Хөгжлийн газрын "ТООН ЗУРГИЙН ТАНИХ ТЭМДЭГ"-ийн дагуу боловсруулсан байна.
- Авто зогсоолын техникийн зураг, тайлбар бичиг, геодезийн тайлан, инженер геологийн дүгнэлт, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувиулж авчрах) тоон хэлбэрээр (dwg болон pdf) архивд, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.

Хянасан:
НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга




В.Мягмар

Боловсруулсан:
НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн



И.Номингэрэл

2024 оны...сарын...-ны өдөр



Газрын зориулалт
Явган зам


Газрын байршил
Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗАР

Хянасан:
НЗХГ-ын БТХ-ийн дарга
Боловсруулсан:
НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн

Хянасан:
НЗХГ-ын БТХ-ийн дарга
Боловсруулсан:
НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн


ТАНИХ ТЭМДЭГ
Төлөвлөлтийн хураа

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ 3Т19-507/10	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ				
	ЭТСХТ-ийн дарга С.Анхбаяр АТХ5603	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ		Ye шат: А/З	
	Архитектор С.Анхбаяр АНХБАЯР	ГҮҮЦЭМГЭСЭН МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР МАХТ 2021.20.24 С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: М1:100	Огноо: 2024.05
	Шалгасан	ТГ Шифр: 2	Зургийн дугаар: 2	Хуудас: 17	

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

АЖЛЫН ДААЛГАВАР



НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЯВГАН ХҮНИЙ, ЗАМ ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03-р сарын 11-ний өдөр Дугаар 2024/03 Улаанбаатар хот

№	Тайлбар
1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05 -ны өдрийн А/234 дугаар захирал
2. Барилга байгууламжийн байршил	- Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил (Улаанбаатар хот)
3. Зориулалт хүчин чадал	Экспертаны өргөн чөлөө (5 шар – Офицеруудын одон) Их тойруугийн гудамж Бага тойруугийн гудамж Олимпын гудамж, Их Монгол улсын гудамж Жанжин Д Сүхбаатарын талбай орчим
4. Төслийн иж бүрдэл	Баримт бичиг иж бүрдэл: - Тайлбар бичиг - Ажлын тоо хэмжээ - Батлагдах /УБЗАА/ Зураг төслийн иж бүрдэл: - Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/ - Хэмжилтийн зураг - Барилгын нэгдсэн төсөв /Магадлалын дүгнэлт /
5. Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	Зураг төсөв нэг үе шаттай: - Зураг төсөв боловсруулж, зөвшилцөж батлуулах - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд зөвшөөрсөн хугацааг үндэслэл болгоно.
6. Арчлалт хамгаалалт	Гүйцэтгэсэн ажлыг баталгаат хугацаанд өөрийн хөрөнгөөр засвар, арчлалтыг тогтмол гүйцэтгэнэ.
7. Төслийн захиалагч	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
8. Хийгдэх тохижилтын ажлууд	Ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэж холбогдох хүмүүстэй зөвшилцөж, төсөвт өртөг багтах хэмжээгээр ажлын зураг төслийг боловсруулна.
9. Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Төсөл хөтөлбөрүүд:</u> - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; <u>Хууль тогтоомжууд:</u> -Газрын тухай хууль



БАТЛАВ
 УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
 БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
 ДАРГА Ц.ТӨРХҮҮ

<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТХХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Гүйцэтгэсэн	МЭРГЭШСЭН АЖЛАХЧИЙН ХАМГААГАГЧИЙН ХАМТЫН ГЭРЭЭНИЙН ХАМТ	Масштаб: М1:100
Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр: 3	Огноо: 2024.05
		Зургийн дугаар: 3	Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI


АЖЛЫН ДААЛГАВАР

	<p>-Барилгын тухай хууль Норм, нормативууд -Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/ -Барилгын геодезын ажил /БНБД 11-08-08/ -Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 -Барилгын бүтэц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хаасралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02 -Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12 -Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм -Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 -Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/ -Бусад холбогдох норм, дүрэм. <u>Стандартууд</u> -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/ - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага UCS 0901B:2022 -Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага UCS 0903B:2022 -Үерээс хамгаалах барилга байгууламжийн төлөвлөлт хийх удирдамж UCS 0501A:2020 -Борооны улирлын усны урсгалын менежментийн төлөвлөгөө UCS 0503A:2020 -Бохир усны цооног, бие даасан цэвэрлэх байгууламж UCS 0704B:2020 -Бусад холбогдох стандартууд</p>
	<p><u>Ажилд тавигдах шаардлага:</u> -Төлөвлөлт хийгдэх талбайн орц гарцыг гол болон туслах замын хөдөлгөөнтэй уялдуулах</p>
<p>10. Онцгой нөхцөл</p>	<p>-Явган ба дугуйн замыг норм дүрмийн дагуу төлөөлөх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг савдгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх; -Ажилд боржин чулууг ашиглах ба олон улсад хийгдэж байгаа чулуун замын хэмжээс, зүсэлт, чулууны өнгө чанартай дүйцэхүйц стандартад хангасан байх бөгөөд халтирахгүй гадаргуутай нөхөн сэргээлтэд дахин ашиглахаар байх; -Байгалийн боржин чулууны зүсэлтийн зузаан 4 см-аас доошгүй байх; -Боржин чулуун хавтанг тавилт, өрөлтийг захиалагч, авторын зураг төслийн дагуу гүйцэтгэх; -Явган хүний боржин чулуун замын ажлыг гүйцэтгэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах, нийтад мэдээллийг тодорхой ойлголт өгөх байдлаар мэдээлэх самбар, хамгаалалтын хөшлөг, тэмдэглэгээг байршуулах, Барилга, замын ажил гүйцэтгэхэд</p>

	<p>иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага UCS 0301B:2022; -Гүйцэтгэлийн ажил эхлэхээс өмнө захиалагч, авторт нарт мэдэгдэж ажлын хуваарийг танилцуулах; -Улаанбаатар хотод шинээр хийгдэхээр төлөвлөж буй дүүжин тээвэр, LRT, метро, тойрог зурдны зам, бусад авто замын трассыг гудамж үзэн төлөвлөлттэй уялдуулах; -Явган хүний замын засвар шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхэд түүнээс гарсан хог хаягдлыг норм стандартыг мөрдөж тээвэрлэх; -Явган замын трассд орсон барилга байгууламж, шат, довжоо, түр байгууламж, өргөтгөл, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах; -Ус зайлуулах шугам сүлжээг төлөөлөх;</p>
<p>11. Эдийн засгийн тооцоо, төсөв</p>	<p>Төсвийг ESTIMATOR-PRO программ тооцож ирүүлэх.</p>
<p>12. Бусад</p>	<p>Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна</p>

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.ОТГОНБАЯР

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ,ТОХИЖИЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
БОЛОВСРУУЛСАН:
ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ,ТОХИЖИЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.БИЛГҮҮН
У.САНЧИР

 <p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	<p>Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж</p> <p>НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ</p> <p>ЭТСХТ-ийн дарга <i>С.Анхбаяр</i></p> <p>Архитектор <i>Саруул Мөнхзул</i></p> <p>Гүйцэтгэсэн <i>МЭРГЭШСЭН АНХБАЯР</i></p> <p>Шалгасан <i>С.Анхбаяр</i></p>	<p>ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ</p> <p>ЕГ Шифр: ХТСИ_05/24</p> <p>Масштаб: М1:100</p> <p>ТГ Шифр: Зургийн дугаар: 4</p>	<p>Ye шат: А/3</p> <p>Огноо: 2024.05</p> <p>Хуудас: 17</p>
--	---	---	--

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

ТАЙЛБАР БИЧИГ

Ерөнхий зүйл: Түгжрэлийг бууруулах чиглэсэн шулуун коридор бүхий явган замын зураг төсөл боловсруулах ажил нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэр хамаарна. Тус ажлыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний дагуу 5 хэсэгт хуваан ажлын зураг төслийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ боловсруулав.

БАЙРШИЛ:
Улаанбаатар хот

Зураг №1



ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН СТАНДАРТУУД:

- Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016
- Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага MNS 5682 2006
- Автозогсоол ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007
- UCS 0901B:2022 Явган хүний зам талбайг төлөвлөлт, хучилт угсралтад тавигдах ерөнхий шаардлага


ОДООГИЙН БАЙДАЛ:

Талбайн судалгааны ажлыг хийхдээ захиалагч байгууллагын төлөөлөлтэй газар дээр нь явж судалсаны үндсэн дээр хийгдэх ажлыг тодорхойлсон.

ЯВГАН ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Явган замын зураг төслийг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний дагуу монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын дагуу төлөвлөвөө.



 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ЗТ19-507/10	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж			Ye шам: А/3 Огноо: 2024.05 Хуудас: 17
	НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			
	ЭТСХТ-ийн дарга	С. Анжбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	
	Архитектор	Н. Мөнхзул	ЕГ Шифр: ХТСИ_05/24	
Гүйцэтгэсэн	С. Анжбаяр	Масштаб: М1:100	ТГ Шифр: Зургийн дугаар: 5	
Шалгасан	С. Анжбаяр	М1:100	Хуудас: 17	

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ:


Одоо байгаа цэвэр, бохир, дулааны холбооны шугамын худгийг явган зам, гарцны уналтын түвшинд тохируулан ширмэн тагаар сольж хүзүүвч хийн одоо байгаа худагтай бэхэлж хийхээр зураг төсөвт тусгалаа.



Зураг №3 Ширмэн тагийг явган замын түвшинтэй нэг түвшинд суулгана.

ЯВГАН ЗАМЫН ХУЧИЛТЫН ХИЙЦ:

- Явган замын хавтан /30x30x4/ - 4-6см
- Явган замын хавтан /30x60x4/ - 4-6см
- Цементээр бэхжүүлсэн элсэн дэвсгэр үе 3см
- Буталсан чулуун суурь үе 15см




Зураг №2

ГАРЦНЫ ТӨЛӨВЛӨЛТ:


Одоо байгаа гарцны уналтууд нь стандартад нийцэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тухтай зорчих нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Иймд гарцны уналтуудын зураг төслийг стандартын дагуу төлөвлөлөө.

ГАРЦНЫ УНАЛТЫН ХУЧИЛТ:


Гарцны уналтын хучилтыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний дагуу бетон хучилттай хийхээр төлөвлөлөө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 30x30x6см хэмжээтэй хөтөч хавтанг ажлын зурагт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.



Зураг №4.



Зураг №5.



<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж			
	НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			
	ЭТСХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	
	Архитектор	Н.Мөнхзул	Ye шат: A/3	
Гүйцэтгэсэн	С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: M1:100	Огноо: 2024.05
Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр:	Зургийн дугаар: 6	Хуудас: 17
ЗТ19-507/10				

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

БАРИЛГЫН АЖИЛ /ТЕХНИКИЙН ШААРДЛАГА/

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

Явган хүний зам, талбайн барилга угсралтын ажлыг хийхдээ гүйцэтгэгч нь зураг төсөл, техникийн шаардлагыг хангасан барилгын материал, хийц, эдлэл болон тоног төхөөрөмж ашиглан барилгын ажлыг гүйцэтгэнэ.

ЯВГАН ХҮН, ДУГУЙН ЗАМЫН ЧАНАР:

Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад мэргэшсэн инженер техникийн ажилчдыг ажиллуулах нь чухал ба ажилчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамруулсан байх шаардлагатай. тухайн ажлын сонгон шалгаруулалтыг зарлахдаа мэргэжлийн зэргийн нотлох баримт, баталгаажуулалтын талаар урьдчилан тусгаж, мэргэшсэн замчид, ажилчдаар барилгын ажлыг гүйцэтгүүлэх нь явган хүний замын чанар, насжилт, эдийн засагт чухал үр нөлөөтэй.

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ҮЕИЙН МЭДЭЭЛЭХ САМБАР БАЙРЛУУЛАХ:

Явган хүний зам, талбайн томоохон бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө сонин хэвлэл, цахим хуудас, дүүрэг хорооны хурлаар дамжуулан иргэдэд мэдээлэхэд анхаарч ажиллах ба барилгын талбайн эхлэл болон төгсгөл хэсэгт мэдээлэх самбарыг заавал байрлуулна.

ХАМГААЛАЛТЫН ХААЛТ, ХАШИЛТ БАЙРЛУУЛАХ:

Явган хүний зам, талбайн барилга угсралтын ажлыг хамгаалалтын хашилтны дотор гүйцэтгэх ба иргэдийг төөрөгдүүлэхгүйгээр зорчих боломж нөхцөлийг заавал хангах шаардлагатай. явган хүний замын ажил эхлэхээс өмнө хийгдэх ажил болон ажлын үе шат бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хамгаалалтын хашилт суурилуулах төлөвлөгөө гаргана.



Зураг №6.

Хамгаалалтын хашилт, түр замын тоноглол (жишээ)

Замын зохицуулагч:

Явган хүний замын ажил хийх үед түр зам байгуулах шаардлагатай талбайд иргэдийн зорчих нөхцлийг хангах зорилгоор замын зохицуулагчийг ажилуулна. Зам барилгын ажлын явцад түр замын урт 10000 мм - 30000 мм хооронд байвал замын зохицуулагчийн 1хүн/өдөр, 30000 мм-ээс их бол замын зохицуулагчийг 2хүн/өдөр буюу замын хоёр талд байрлуулж ажиллуулна. Замын зохицуулагчийн ажлын хувцас хэрэглэлд шар хантааз, ажлын үнэмлэх, хамгаалалтын малгай, гутал, цагаан бээлий, дохиур мод, шүгэл багтана.

Явган хүний түр зам байгуулах:

Явган хүний зам, талбайн барилгын ажлыг хийж гүйцэтгэх явцад явган зоригчдын ая тух, аюулгүй байдлын үүднээс заавал түр явган зам байгуулна. Барилгын ажлын үед түр зам гаргах боломжийг бэлтгэх ажлын үед судалж, орон зай хангалттай тохиолдолд шинээр барих болон шинэчлэх явган хүний замын хажуу талд түр замыг гаргана.

Явган хүний замын өргөн 4000 мм-ээс дээш бол барилгын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх технологийн дагуу хийх ба харин 4000 мм-ээс бага өргөнтэй, түр зам гаргах боломжгүй тохиолдолд авто зам дээр хаалт явган зорчигчдыг чөлөөтэй зорчих нөхцлийг заавал бүрдүүлж өгнө.

Явган хүний замын хучлага байгуулахаас өмнө явган зорчигч барилгын талбайгаар өнгөрөн гарах шаардлага үүсвэл суурийн доод үе, суурийн үеийг сайтар нягтруулсан байх ёстой бөгөөд резинэн зөөлөвчтэй шалавч, модон хавтанг дэвсэж зорчигчийн аюулгүй байдлыг хангана. Түр зам дэвссэн шалавчийг хотын өнгө үзэмжинд нийцсэн халтирдаггүй материалаар хийгдэнэ. Түр зам байгуулаагүй эсвэл ямар нэгэн байдлаар түр замыг шийдээгүй бол захиалагч болон хариуцсан албан тушаалтан ажлыг зогсоох тухай шийдвэр гаргана.



Зураг №7.

БАРИЛГА УГСРАЛТЫН ТАЛБАЙН БЭЛТГЭЛ:

Барилга угсралтын ажлыг талбайд материал, хийц эдлэл хураахдаа хамгаалалтын хашилт барьж нэг цэгт төвлөрүүлнэ. мөн замын хавтан зүсэх ажилбараас үүсэх тоосжилтоос хамгаалах арга хэмжээ авч иргэдийн тав тухыг алдагдуулахгүй байхад анхаарна. барилгын материалыг хураан цэгцлэхдээ гадуур нь хашилт байрлуулж, осол аваар гарахаас сэргийлнэ. Барилга угсралтын ажлын үед орчны бохирдол үүсэхээс сэргийлсэн арга хэмжээг авч ажиллана.

ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТЫН БҮТЭЭЦ:

Хучилтын бүтээц нь хучлага, суурь болон суурийн доод үеүдээс бүтнэ.

СУУРИЙН ДООД ҮЕИЙН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА: Суурийн доод үеийн материал нь органик бодис, өгөршсөн буюу хэврэг материал, хоёрдагч (шавар) эрдэс бодис, хавтгай буюу хайрслалт материал (миканит), зөөлөн чулуу, тэлэх чадвартай эрдэс бодис, химийн нөлөөнд хялбар ертдөг материал, уусдаг давс зэргийг агуулаагүй байна.

Суурийн доод үеийн материалын ширхэглэлийн бүрэлдэхүүн

Шигшүүрээр өнгөрөх жингийн эзлэх хувь (%)								
50MM	37.5MM	25.0MM	19.0MM	9.5MM	4.75MM	2.00MM	0.425MM	0.075MM
100	90~100	80~100	60~90	30~65	25~55	15~40	8~20	2~8

<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	Үе шат: А/3	
	ЗТСХТ-ийн дарга С.Анхбаяр 21.126	Архитектор М.Мөнхзул АНХБАЯР	Гүйцэтгэсэн МЭРГЭШСЭН АЖИЛЧ МА.У.	Шалгасан С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: М1:100
					ТГ Шифр: 7	Огноо: 2024.05
					Зургийн дугаар: 7	Хуудас: 17

1-020
 2024 7 4

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

БАРИЛГЫН АЖИЛ /ТЕХНИКИЙН ШААРДЛАГА/

НЯГТРУУЛАЛТ:

Суурийн доод үеийн хуурай үеийн хамгийн их нягт 90% -иас дээш байхаар жигд нягтруулна. Нягтруулах үеийн чийгийг агууламжийн хүлцэх алдаа $\pm 2\%$ байна. Нягтруулалтын үеийн зузааныг 150 мм байхаар тарааж, гадна талаас дотогшоо чиглэлд нягтруулалтыг гүйцэтгэнэ. Ус зайлуулах байгууламж болон үзлэгийн худаг зэрэг зам дээрх байгууламж орчмын хөрсийг нягтруулахдаа тухайн бүтээцийг эвдэрч гэмтэхгүй хөдлөхгүй байхад анхаарна. Нягтруулагч машин талбай руу орох боломжгүй үед булт индүү, доргиурт гар нягтруулагч эсвэл гараар нягтруулах аргыг хэрэглэнэ.



Зураг №8.

Нягтруулалтыг 500 м² тутамд багадаа нэгээс доошгүй удаа талбайн туршилт хийж дүгнэлт гаргана.

СУУРИЙН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Явган хүний замын барилгын ажлын дараа хавтанд суулт үүсэх хагарах зэрэг асуудал нь янз бүрийн шалтгааны улмаас үүсдэг боловч ихэвчлэн суурийн үед ашиглаж буй материалын ширхэглэл болон нягтруулалттай холбоотой байдаг.

Суурийн үеийн ширхэглэлийн бүрэлдэхүүн Шигшүүрээр өнгөрөх жингийн эзлэх хувь (%)

50MM	37.5MM	25.0MM	19.0MM	9.5MM	4.75MM	2.00MM	0.425MM	0.075MM
100	90~100	80~100	60~90	30~65	25~55	15~40	8~20	2~8

ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН ЭЛСЭН ДЭВСГЭР ҮЕ ДЭЭР ЯВГАН ХҮНИЙ ЗАМ БАРИХ

Явган хүний зам болон талбайд ирэх ачаалал харьцангуй бага тохиолдолд явган хүний замын чулуун ба бетон хавтанг 2%-ийн цементээр бэхжүүлсэн элсэн дэвсгэр үе дээр суулгах ба дараах аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

ЦЕМЕНТ

Цемент нь ердийн буюу портланд цемент байх бөгөөд AASHTO M-85-07, MNS 974:99 болон бусад олон улсын стандартуудын шаардлагад нийцсэн байна. Цементийн орцыг 1м²-д 2кг цемент байхаар тараана.

СУУРИЙГ БЭЛТГЭХ:

Урьдчилан бэлтгэсэн талбайд элсийг 100 мм зузаантайгаар дэвсэж, элсийг зохих багаж хэрэгслийн тусламжтайгаар, налуу ба түвшинг хангах хэмжээнд сайтар тарааж тэгшилнэ. Тэгшилсэн үеийг 1 м 2-д 10 л -ээс доошгүй усыг жигд цацаж услан, гар доргиулагчаар сайтар нягтруулна.

ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХАШЛАГА СУУЛГАХ

Хашлаганы суурийн нүхийг зохих өргөн, гүнд ухаж нягтруулан, ажлын зурагт заасан маркын бетон зуурмаг ашиглан дэвсгэр үе хийж, хашлагыг нэг талаас нь эхлэн суурилуулж, ар хананы манаасыг хийнэ.

НЯГТРУУЛАЛТ:

Суурийн үеийг хуурай үеийн хамгийн их нягт 90% -иас дээш байхаар жигд нягтруулж, нягтруулах үеийн чийгийг $\pm 2\%$ түвшинд баримтална. Ус зайлуулах байгууламж болон үзлэгийн худаг зэрэг зам дээрх байгууламж орчмын хөрсийг нягтруулахдаа эвдэрч гэмтэхгүй хөдлөхгүй байхад анхаарна. Нягтруулагч машин талбай руу орох боломжгүй үед булт индүү, доргиурт гар нягтруулагч эсвэл гараар нягтруулах аргыг хэрэглэнэ. Инженерээс урьдчилан зөвшөөрөл авахгүй барилгын ажлыг явуулсан тохиолдолд ажлыг дахин гүйцэтгэнэ.



Зураг №9.


ХҮЛЦЭХ АЛДАА:

Гадаргуугийн түвшний хамгийн их зөрүү мм байна ± 15 мм байна.

ЯВГАН ЗАМЫН ХАВТАНТ ХУЧЛАГА:

Хавтант хучлагыг явган хүний замаас гадна авто зам, зогсоолд өргөн ашигладаг. Хавтант хучлагын чанарыг бататгахын тулд хавтан хоорондын зайн хэмжээг баримтлах ба завсраар нь дүүргэх элсний чанар ч мөн адил чухал үүрэгтэй байдаг. Явган хүний замын хучилтын бүтээцийн давхаргуудад ашиглаж буй материал болох хавтан, элс хайрга, зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй суурийн материалуудын физик чанарууд нь чухал элемент учраас материал сонголтонд анхаарна.

	Зориулалт	Хавтангийн төрөл	Зузаан	Гулзайлтын бат бэх (МПа)	Шахалтын бат бэх (МПа)
Хавтан	Явган хүний зам, талбайд	Хязгаарлахгүй	≥ 60 мм	5 дээш	20 дээш
	Зогсоолд	Зиг заг болон тоосгон хэлбэртэй	≥ 80 мм		42 дээш



<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Члаандаатар хот, Хан Чул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ		Үе шат: A/3
	ЗТСХТ-ийн дарга Архитектор Гүйцэтгэсэн	С.Анхбаяр Н.Мөнхээл С.Анхбаяр	МА-ХТ 2024.05.24	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: M1:100	Огноо: 2024.05
	Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр: 8	Зургийн дугаар: 8	Хуудас: 17	

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

VI

Хавтан хоорондын зайг тохируулан, хавтангийн төрлөөс хамааран өрөлтийг зөв хийснээр дээрээс ирэх ачаалал жигд хуваарилагдаж хавтанд эвдрэл үүсэхгүй. Мөн хавтан хоорондын зайг зөв тохируулснаар таягтай болон тэргэнцэртэй иргэд ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлдэг. Явган хүний замын хавтан өрөхөд хоорондын зай нь хавтангийн хэмжээнээс хамаарна.

Хавтан	Хавтан хоорондын зай
Том хавтан	3 мм
Жижиг хавтан	2 мм

ХАВТАНТ ХУЧЛАГЫН ЭЛСЭН ДЭВСГЭР ҮЕ: Явган хүний замын элсэн үе хавтангаас ирэх ачааллыг хуваарилж хавтангийн тэгш байдлыг хангах үүрэг гүйцэтгэдэг. Элсэн үед ашиглах материал гүйцэтгэлийн чанараас шалтгаалж хавтангийн өрөлт овор товонтой жигд биш болдог тул материал гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

ЭЛСЭН МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА: Хавтангууд хөдөлгөөнгүй байх чанарыг дээшлүүлэхийн тулд завсарт нь элсээр чигжих, хавтангийн тэгш байдлыг хангаж дээрээс ирэх ачааллыг жигд хуваарилах үүрэг гүйцэтгэдэг.


Элсэн материалд тавих шаардлага		
Ангилал	Ширхэглэлийн хэмжээ	Бусад
Хавтангийн заадсанд ашиглах элс	Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ: 2.5 мм-ээс доош; 0.08 мм-ийн хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ: 10%-с доош;	Элсийг зөвхөн хатааж хэрэглэх
Элсэн үе	Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ: 5.0 мм-ээс доош; 0.08 мм-ийн хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ: 5%-с доош;	-

ХАВТАН ХООРОНДЫН ЗААДСЫГ ЭЛСЭЭР ДҮҮРГЭХ ТЕХНОЛОГИ: Хавтангийн заадас дүүргэгч материал болох элсийг нойтон хэлбэрээр ашиглахгүй. Заадас дүүргэгч элсийг хавтангийн налуу ирмэгийн доод түвшин хүртэл хийнэ. Суурийн үеийг суултаас хамгаалахын тулд сууринд элсийг жигд тараан дэвсэх ба хөндлөн хэвгийг болон замын чигийг тодорхойлж гар аргаар хэвтээ чиглэлд тэгшилгээ хийнэ.




Зураг №10. Элсэн дэвсгэр үеийн гүйцэтгэл

ХАВТАНГИЙН ГАДАРГУУГ НЯГТРУУЛАХ: Явган хүний замын хавтан өрөлтийг хийсний дараа шаардлага хангасан хуурай элсийг хавтан хоорондын зайд чигжин резинэн ултай нягтруулагчаар нягтруулна. Хавтан хоорондыг элсээр чигжих нь хавтан өрөлтийн гүйцэтгэлд чухал үүрэг гүйцэтгэдэг тул элсэн чигжээсийг шаардлагын дагуу хийхгүй бол хавтан хөдөлгөөнд орох, суулт өгөх, эвдрэх шалтгаан болдог учраас дараах байдлаар хийнэ.




Зураг №11.

ХӨНДЛӨН ХЭВГИЙГ ТАЛБАЙ ДЭЭР ГАРГАХ: Явган хүний замын гадаргуун усыг саадгүй урсгах нөхцөлийг хангахын зэрэгцээ явган зорчигчийн тав тухтай орчинг бүрдүүлэхийн тулд хөндлөн хэвгийг 2% -иас доош байхаар гүйцэтгэнэ. Явган хүний замын хөндлөн хэвгийг суурийн доод үеэс эхлэн гаргана. Хэрэв суурийн доод үеэс хэвгийг гаргаагүй элсэн дэвсгэр үе дээр хэвгийг гарган хийвэл явган хүний замд суулт үүсэх аюултай.



Зураг №12.

ХАВТАНГ ӨРӨХ, СУУЛГАХ: Явган хүний замын хавтанг өрөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал, тав тухтай байдлыг хангах зорилгоор тэгш байдал, хавтан хооронд зай завсаргүй байх чанарыг тооцож материалд тавих шаардлага болон барилга угсралтын шаардлагыг мөрдөнө.




<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			
	ЗТСХТ-ийн дарга С.Анхбаяр	Архитектор Н.Мөнхзул	Гүйцэтгэсэн Р.Вамбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Шалгасан С.Анхбаяр	МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР М.М.М.	МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР М.М.М.	ЕГ Шифр: ХТСИ_05/24 Масштаб: М1:100 ТГ Шифр: Зургийн дугаар: 9
	21-26-АТХ603	2021-07-04	2021-07-04	Үе шат: А/3 Огноо: 2024.05 Хуудас: 17


ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

Хавтангууд хоорондох зайгүй нягт байх чанарыг хангахын тулд дараах зүйлсийг шалгаж хянасан байна. хавтан суулгахаас өмнө материалын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан лабораторт шинжлүүлнэ. мөн тухайн газарт зориулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн газрыг өөрчилж болохгүй. Учир нь үйлдвэрлэлийн газрыг өөрчилснөөр хавтангийн геометр хэмжээ өөрчлөгдөх сөрөг талтай юм. мөн тухайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг урьдчилан авч уг хавтангийн хэмжээгээр хашлага суулгах өргөний зайг тогтоож, хавтангуудыг өрөхөд өргөдөх болон дутах эрсдлийг тооцно. Явган хүний хавтант хучлагатай хийцэд хавтанг буруу өрснөөс үүдэн эвдрэх магадлал их байдаг тул өрөлтөнд гол анхаарлыг хандуулах нь чухал.

- Хавтанг механик зүсэгчээр өө сэвгүй тайрч, тэгшхэн хийх.
- Жижиг дөрвөлжин хавтан ашиглах
- Үзлэгийн хугдгийн таг замын хавтантай ижил түвшинд байх
- Заадас 2-3мм хэмжээтэй байх.



Зураг №13.



Зураг №14.


ХАШЛАГА СУУЛГАХ.

Замын хашлага суулгахад хэв хашмал угсрах, хашлага хоорондын зай, бетон суурийн цутгалтын үе шат зэргийг анхаарч бэхжилтийн хугацаанд барилгын талбайд хашилт барьж хамгаалан барилгын ажлыг хийнэ. Замын хашлагын хэв хашмалыг угсрахаас өмнө суурийн үеийн нягтруулалтыг шалган, суурийн бетон цутгахдаа замын хашлагыг хөдөлгөөнгүй байхад анхаарна. Замын хашлага суулгахаас өмнө орчныг цэвэрлэх ба барилгын ажлын үед зөөж тээвэрлэх явцад эвдэрсэн хашлагыг ашиглаж болохгүй. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой. Замын хашлага суулгах байршилд чигийн тэгш байдлыг хангаж утас татна. Хашлагын суурийн эхний бетон зуурмагийг зураг төсөлд заасан хэмжээгээр бага багаар дүүргэн хүрэээр жигд тарааж дээд талын хэсгийг тэгшилж засна. Бетон цутгахдаа зай завсар гаргахгүйн тулд саваа модоор жигд тараана. Хашлагыг суулгахдаа хоорондын 5-10 мм зайг баримтлах бөгөөд 1 x 2 харьцаатай элс цементэн зуурмагийг хашлага хоорондын завсарт дүүргэнэ. Замын хашлага нь сууриндаа ямар нэгэн хөдөлгөөнгүй суусан байна. Хашлага суулгах ажлын хүлцэх алдаа

Төрөл	Хүлцэх алдаа	Шалгах давтамж		Шалгах арга
		Хамрах хүрээ	Шалгах хэмжээ	
Хашлагын цулуун ба алгуур байдлын хэмжээ	±8	100 у/м тутамд	1 цэгт	20 метрийн урттай утас татаж хамгийн их утгыг авна
Зэргэлдээ хашлаганы өндрийн зөрүү	±2	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна
Завсрын өргөн	±3	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна
Хашлагын өндөржилт	±6	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна
Гадагш цулуун хэмжээ	±10	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна

ҮЗЛЭГИЙН ДУГУЙ ХУДАГ, ТРАНШЕЙНЫ НҮХ ОРЧМЫН ХАВТАН ӨРӨЛТ

Үзлэгийн хугдгийн тагийг замын хавтангийн хээтэй нийцүүлэн хийж болно. Үзлэгийн худаг орчмын хавтанг өрөхөд хавтан хугдгийн тагтай амлан нийлэх хэрэгтэй. Зайлшгүй шалтгааны улмаас нийлэх боломжгүй үед бетоноор шавах боломжтой бөгөөд энэ үед үзлэгийн худаг төмөр тагтай байвал 100мм-ээс бага, жижиг хавхлагатай байвал 50 мм-ээс бага хэмжээгээр хавтантай өнгө дагуу бетон цутгана.





Зураг №15.



Зураг №16.

Төлөвлөж буй явган зам, дугуйн зам, гарцны уналтын барилгын ажлыг хийхдээ монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм стандарт, зураг төсөл болон явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682 2006-г баримтлан хийнэ үү.



 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ 3Т19-507/10	Члаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ Ye шат: A/3 Огноо: 2024.05 Хуудас: 17
	ЭТСХТ-ийн барьцаа 21-126	С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	
	Архитектор Аруулбал	Н.Мөнхзул	Масштаб: М1:100	
	Гүйцэтгэгч Г.Батбаяр	Г.Батбаяр	ТГ Шифр: Зургийн дугаар: 10	
Шалгасан 2024.05.04	С.Анхбаяр			

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

ГАРЦНЫ УНАЛТ (РАМП)-ЫН БЕТОН ХУЧИЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

Гарцны уналт буюу рампын бетон хийцийн цутгалтын ажлыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх аргачлалд ороогүй зүйлсийг Захиалагчийн инженертэй газар дээр нь зөвшилцөн гүйцэтгэх ба инженерийн зааварчилгаагаар ажлын аргачлал болон ажлын гүйцэтгэлд өөрчлөлт орж болно.

АЖЛЫН ДАРААЛАЛ :

- Гарцны уналт хийх хэсгийг ухаж бэлтгэх
- Гарцны уналт хийх хэсгийг цэвэрлэх.
- Гарцны хэсгийн суурийн нягтруулалтыг хийх
- Хэв хашмал зангидаж , манаас хийж өгнө.
- Гарцны уналт хийх хэсгийг дахин сайтар цэвэрлэх.
- Ус тусгаарлагч дэвсэж бетон зуурмагийн ус газар нэвчихээс сэргийлэх
- В 30 ангийн бетоноор цутгалт хийнэ.
- Бетон зуурмагийг сайтар чигжиж , цул бетон болгож өгөх
- Бетоны гадаргуун өнгөлгөөг цахилгаан багажаар эсвэл гараар маш сайн хийнэ.
- Гадаргууг барзгаржуулах (Нэгэн жигд шүүрдэх)
- Цутгалт авснаас хойш 3 хоногийн турш усан арчилгаа хийх (Хэт халуун , хуурай уур амьсгалтай өдрүүдэд усан арчилгааг өдөрт 2-3 удаа хийх)
- Бетоны хэв хашмалыг 3 хоногийн дараа авч болно (Бетоны талбайн бат бэх хангагдаагүй нөхцөлд усан арчилгааг 7 хүртэл хоног хийх ба Захиалагчийн инженерийн зааварчилгааны дагуу дараагийн шатны арга хэмжээг авна)

ХЭМЖИЛТ ШАЛГАЛТ :

- Бетон сорьцын шоо авч бат бэхийн туршилт хийнэ .
- Бетон цутгалт авахаас өмнө цэвэрлэгээг сайтар хийсэн болон хэмжээг зураг төслийн дагуу зөв тавьсан эсэхийг шалгана.
- Гарцны уналтын бетонд ан цав гарсан эсэхийг шалгана.
- Цууралт ан , цав гарсан эсэх , өнгөлгөө тэгшилгээг шалгах , гарцны уналтын түвшин зурагт заасны дагуу эсэхийг 2 метрийн рейк дээр тэгш ус барьж шалгана.
- Гарцны уналтыг авто замын зорчих хэсэгтэй нийлэх хэсгийг онцгой анхаарч , тэгш байдлыг сайтар шалгах

АНХААРАХ ЗҮЙЛ :


Гарцны уналтыг авто замын зорчих хэсэгтэй нийлэх хэсгийг онцгойлон анхаарах Халуун, хуурай уур амьсгалтай үед нимгэн хальсан бүрхүүл, усаар шүрших зэрэг аргаар чийгийн ууршилтаас хамгаалахаас гадна цементийн гидратацийг түргэсгэх болон бэхжилтийн процессыг түргэсгэхэд нимгэн полиэтилен бүрхүүл хучаас бичил орчин бүрдүүлэх сайн талтай байдаг.


Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорхи товчилсон үгсийг ашиглав:

AASHTO	Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)
ASTM	Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг
BS	Британы стандарт
BSCP	Британы стандарт
ISO	Олон улсын стандартчилалын байгууллага

Доор дурьдсан ажлуудын нарийвчилсан техникийн шаардлагыг " Авто зам , замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага " ЗЗБНБД 31-008-2016 нормд заасны дагуу авч хэрэглэх ба энэхүү аргачлалд заагаагүй бусад ажлуудыг дээрх техникийн шаардлага болон бусад холбогдох норм , стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

- БЕТОН ХОЛЬЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ
- БЕТОНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ
- БЕТОНЫГ ХОЛИХ БЕТОН ХОЛЬЦЫГ ТЭЭВЭРЛЭХ
- ШИНЖИЛГЭЭ ХИЙХ
- ШООНЫ ТУРШИЛТ ХҮЧИНТЭЙ БАЙХ
- БЕТОНЫ БАТ БЭХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТУРШИЛТУУД
- БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ
- БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ
- ХЭВЛЭМЭЛ БА ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ
- ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЦЕМЕНТИЙН УУСМАЛ БА ЗУУРМАГ)
- БЕТОН ЦУТГАЛТЫН АЖЛЫН БҮРТГЭЛ
- СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ



 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ 3Т19-507/10	Улаанбаатар хот, Хан Чул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ					
	ЭТСХТ-ийн дарга <i>С.Анхбаяр</i>	Архитектор <i>Н.Мөнхзүл</i>	Гүйцэтгэсэн <i>Г.Ватбаяр</i>	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	Ye шам: A/3	
	Шалгасан <i>С.Анхбаяр</i>	МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР <i>Г.Ватбаяр</i>	Шалгасан <i>С.Анхбаяр</i>	ЕГ Шифр: ХТСИ_05/24 ТГ Шифр:	Масштаб: М1:100 Зургийн дугаар: 11	Огноо: 2024.05 Хуудас: 17
				3Т19-507/10	17	

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

14
VI

1. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА :

Гүйцэтгэгч бетонд ашиглахаар төлөвлөж байгаа материалын тухай бүрэн мэдээллийг Захиалагчийн инженер танилцуулна . Инженер бүх материалыг зөвшөөртөл бетон дэвсэж болохгүй . Нэгэнт Инженерийн зөвшөөрсөн материалыг солих буюу өөр материалаар орлуулж болохгүй . Материалын нарийвчилсан техникийн шаардлагыг " Авто зам , замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага " ЗЗБНБД 31-008-2016 нормоос үзнэ үү .

Материалын нэр	Материалд тавигдах ерөнхий шаардлага
Цемент	Цементбетон хучилтанд хэрэглэгдэх цемент нь AASHTO M 85-11-ийн шаардлагуудыг хангасан , 42.5 МПа маркаас багагүй байна .
Чулуу	Бетон орцонд хэрэглэгдэх чулууг чулуун ордоос гаргаж авсан буталсан чулуу хэрэглэнэ . Чулууны шахалтын бат бэх нь бетоны шахалтын бат бэхээс 1.3 дахин их байна . Бетонд хэрэглэгдэх чулууны хамгийн том хэмжээ нь 20 мм ээс ихгүй байна .
Элс	Цэвэр , хатуу ба бүх байгалийн гаралтай элс , буталсан хайрган элс эсвэл AASHTO M 6-08 стандартад нийцэж байгаа буталсан чулуун элсийг бетон зуурмагт ашиглана .
Ус	Бетон зуурмаг болон арчилгаанд хэрэглэх ус нь тос , хүчил , шүлт , сахар , давс , органик бодис болон бусад сөрөг нөлөөтэй бодис агуулахгүй байна . Ус нь MNS AASHTO T 26:2005/ AASHTO T 26-79 (2008) стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нь шинжилж , Захиалагчийн инженер зөвшөөрвөл усны pH үзүүлэлт 6.0 - 8.5 хооронд байж болно .

Хуучин бетон гадаргууд шинэ бетон цутгахаас өмнө дараахи арчлалтыг хийнэ : Хуучин бетон гадаргууг чулуун материалыг ил гартал нугардаггүй хялгасан шүүрээр угаана . Хуурай , чулуун материал нь ил гарсан гадаргуу дээр шинэ бетон цутгана . Гадаргуу нь цэвэр , хатуу , хуурай ба бат бэх байна . Хэрэв угаах явцад гадаргуун хагаралууд цэвэрлэгдэж ил гарвал тэдгээрийг шавар буюу бетон зуурмагаар дүүргэж бөглөнө . Нэг удаад дүүргэх зуурмагийн хэмжээг гадаргууд бетон дэвсэхэд дүүргэсэн зуурмаг хатаагүй байхаар тааруулна .

(в) Цутгах дараалал Гүйцэтгэгч хэрэв бололцоотой бол бүтээцийн нэг хэсэг дэх босоо элементүүдийн цутгалтын хоорондох хугацааг ижил байлгах арга хэмжээ авна . Энэ хугацаа нь Инженер өөрөөр заагаагүй бол цаг агаарын таатай нөхцөлд 3-7 хоног байна . Хэрэв Инженер бетоны агшилтын улмаас ажлын залгаасыг багасгахыг шаардвал шинэ бетон хольцыг 21 хоног болоогүй гадаргууд дэвсэхгүй . Хэрэв зурагт ажлын залгаас хийхээр үзүүлсэн бол тэдгээрийн өргөн ба урт нь зурагт заасан хугацааг өнгөртөл тэдгээрийг дүүргэж болохгүй .

3. БЕТОНЫГ АРЧЛАХ

Ерөнхий

Бетоныг арчлах нь бэхжих явцад бетон чийгшлээ алдаж хатуурах ба бетоны доторх температурын өөрчлөлтөөс болж дулааны хагарал үүсэх зэргээс хамгаална .

Бетоныг арчлах арга нь бетоныг гэмтээхээргүй байна . Бэхжилт нь дээрх шаардлагыг хангатай үргэлжлэх боловч аль ч тохиолдолд 7 хоногоос багагүй байх ба дээр нь дараагийн бүтээц иртэл үргэлжилнэ .

Бетоны арчлалтыг арчлах ажиллагааг даах чадвартай болтол хатуурсан нөхцөлд эхлэх бөгөөд тасралтгүй буюу нилээд том талбайд цутгаж байгаа бол түрүүчийн цутгалт нь дууссан газраас эхэлж хийнэ .

Шинээр дэвссэн бетон бүрийг энд дурьдсан аргуудын аль нэгээр бетон хуурайшихаас сэргийлж арчилна . Арчлалт хийхээр сонгосон аргаа хэрэглэж амжаагүй байхад бетон хуурайшиж эхэлбэл бетоны гадаргууг гэмтээлгүйгээр ус цацаж чийгтэй байлгана .

Уураар болон туяагаар халаахаас бусад аргаар хүснэгт 3-м өгөгдсөн хугацаанд зогсолтгүй үргэлжлүүлэн арчилна .

2. БЕТОН ХОЛЬЦЫГ ЦУТГАХ

(а) Цутгах зөвшөөрөл Инженер бичгээр зөвшөөрөл өгтөл ямар ч бетоны ажлыг эхэлж болохгүй . Гүйцэтгэгч бетон г цутгах гэж байгаа тухайгаа 24 цагийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ .

Бетон цутгаж эхлэхээс өмнө хэв хашмалаас өмнөх цутгалтаас үлдсэн хольцны үлдэгдэл болон бусад гадны материал хогийг гаргаж хаяна .

Инженер зөвшөөрөл өгсөнөөс хойш 24 цагийн дотор бетон цутгах ажлыг эхлүүлнэ . Хэрэв Гүйцэтгэгч энэ хугацаанд цутгалтыг эхэлж чадахгүй бол Инженерийн зөвшөөрлийг хүчингүйд . тооцож Гүйцэтгэгч дахин зөвшөөрөл авна

(б) Бетон дэвсэх гадаргууг бэлдэх Бетон цутгах нүхийг энэ техникийн шаардлагын дагуу бэлдэнэ . Нүхэнд тогтсон усыг шуудуу татах буюу бусад тохирох аргаар зайлуулна . Гүйцэтгэгч шинээр цутгасан бетон болон түүний бүрэлдхүүн хэсгүүдийг угаагдахаас хамгаална . Ухмалын ёроолоос доош хийгдсэн аливаа ус зайлуулах хоолой буюу нүхийг шаардлагагүй болмогц Инженерийн зөвшөөрсөн аргаар бөглөж шавардсан байна .



<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Члаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			
	ЭТСХТ-ийн дарга С. Анхбаяр	Архитектор Н.Мөнхзул	Гүйцэтгэгч Г.Батбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Шалгасан С. Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: М1:100	Ye шам: А/3
	ТГ Шифр: 12	Зургийн дугаар: 17	Огноо: 2024.05	Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

15 VI

Арчлалтын хамгийн бага хугацаа

Цементайн төрөл	Орчны дундаж температур 15° C -ээс их	Орчныдундаж температур 5° C-15° C	Орчны дундаж температур 5° C -ээс бага
10%-аас бага пуццоллан нэмсэн портланд цемент	7 өдөр	10 өдөр	14 өдөр
10%-аас их пуццоллан нэмсэн портланд цемент	10 өдөр	15 өдөр	20 өдөр

	<p>-Барилгын тухай хууль Норм, нормативууд: -Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/ -Барилгын геодезын ажил /БНБД 11-08-06/ -Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 -Барилгын бүтээц ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хаасралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02 -Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12 -Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, мөгадлал хийх дүрэм -Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 -Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/ -Бусад холбогдох норм, дүрэм, <u>Стандартууд</u> -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/ - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага UCS 0901B:2022 -Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага UCS 0903B:2022 -Үерээс хамгаалах барилга байгууламжийн төлөвлөлт хийх удирдамж UCS 0501A:2020 -Борооны улирлын усны урсгалын менежментийн төлөвлөгөө UCS 0503A:2020 -Божир усны цооног, бие давсам цэвэрлэх байгууламж UCS 0704B:2020 -Бусад холбогдох стандартууд</p>
	<p><u>Ажилд тавигдах шаардлага:</u> -Төлөвлөлт хийгдэх талбайн орц гарцыг гол болон туслах замын хөдөлгөөнтэй уялдуулах</p>
<p>10. Онцгой нөхцөл</p>	<p>-Явган ба дугуйн замыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх; -Ажилд боожин чулууг ашиглах ба олон улсад хийгдэж байгаа чулуун замын хэмжээс, зүсэлт, чулууны өнгө чанартай дүйцэхүйц стандартад хангасан байх бөгөөд халтирахгүй гадаргуутай нөхөн сэргээлтэд дахин ашиглахаар байх; -Байгалийн боржин чулууны зүсэлтийн зузаан 4 см-аас доошгүй байх; -Боржин чулуун хавтанг тавилт, өрөлтийг захиалагч, авторын зураг төслийн дагуу гүйцэтгэх; -Явган хүний боржин чулуун замын ажлыг гүйцэтгэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах, нийтад мэдээллийг тодорхой ойлголт өгөх байдлаар мэдээлэх самбар, хамгаалалтын хашлага, тэмдэглэгээг байршуулах, Барилга, замын ажил гүйцэтгэхэд</p>

	<p>иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага UCS 0901B:2022; -Гүйцэтгэлийн ажил эхлэхээс өмнө захиалагч, аворт нэрт мэдэгдэж ажлын хуваарийг танилцуулах; -Улаанбаатар хотод шинээр хийгдэхээр төлөвлөж буй дүүжин тээвэр, LRT, метро, тойрог хурдны зам, бусад авто замын трассыг гудамж үзэн төлөвлөлттэй уялдуулах; - Явган хүний замын засвар шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхэд түүнээс гарсан хог хаягдлыг норм стандартыг мөрдөж тээвэрлэх; -Явган замын трассд орсон барилга байгууламж, шат, довжоо, гүр байгууламж, өргөтгөл, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах; -Ус зайлуулах шугам сүлжээг төлөвлөх;</p>
<p>11. Эдийн засгийн тооцоо, төсөв</p>	<p>Төсвийг ESTIMATOR-PRO программ тооцож ирүүлэх.</p>
<p>12. Бусад</p>	<p>Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.</p>

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.ОТГОНБАЯР

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ,ТОХИЖИЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
БОЛОВСРУУЛСАН:
ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ,ТОХИЖИЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.БИЛГҮҮН
У.САНЧИР

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ЗТ19-507/10	Улаанбаатар хот, Хан Чул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЗТСХТ-ийн дарга  Архитектор  Гүйцэтгэсэн  Шалгасан 	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	Ye шам: A/3
	EG Шифр: ХТСИ_05/24	Масштаб: M1:100	Огноо: 2024.05
	ТГ Шифр: 	Зургийн дугаар: 4	Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

178
VI

ТАЙЛБАР БИЧИГ

Ерөнхий зүйл: Түгжрэлийг бууруулах чиглэсэн шулуун коридор бүхий явган замын зураг төсөл боловсруулах ажил нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэр хамаарна. Тус ажлыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний дагуу 5 хэсэгт хуваан ажлын зураг төслийг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ боловсруулав.

БАЙРШИЛ:
Улаанбаатар хот

Зураг №1



ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН СТАНДАРТУУД:

- Авто зам төсөллөх ЗЗБНБД 22-004-2016
- Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага MNS 5682 2006
- Автозогсоол ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007
- UCS 0901B:2022 Явган хүний зам талбайг төлөвлөлт, хучилт угсралтад тавигдах ерөнхий шаардлага

ОДООГИЙН БАЙДАЛ:

Талбайн судалгааны ажлыг хийхдээ захиалагч байгууллагын төлөөлөлтэй газар дээр нь явж судалсаны үндсэн дээр хийгдэх ажлыг тодорхойлсон.

ЯВГАН ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Явган замын зураг төслийг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний дагуу монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын дагуу төлөвлөлөө.

1-020
DM
2024.07.04

Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж					
НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ					
<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p>	ЭТСХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ		Үе шат: А/3
	Архитектор	Саруул Н.Мөнхзул	ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
	Гүйцэтгэгсэн	М.Эршэн	ХТСИ_05/24	М1:100	2024.05
ЗТ19-507/10	Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:
			5	5	17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ:


Одоо байгаа цэвэр , бохир , дулааны холбооны шугамын худгийг явган зам , гарцны уналтын түвшинд тохируулан ширмэн тагаар сольж хүзүүвч хийн одоо байгаа худагтай бэхэлж хийхээр зураг төсөвт тусгалаа .



Зураг №3 Ширмэн тагийг явган замын түвшинтэй нэг түвшинд суулгана.

ЯВГАН ЗАМЫН ХУЧИЛТЫН ХИЙЦ:

- Явган замын хавтан /30x30x4/ - 4-6см
- Явган замын хавтан /30x60x4/ - 4-6см
- Цементээр бэхжүүлсэн элсэн дэвсгэр үе 3см
- Буталсан чулуун суурь үе 15см




Зураг №2

ГАРЦНЫ ТӨЛӨВЛӨЛТ:


Одоо байгаа гарцны уналтууд нь стандартад нийцэхгүй , хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тухтай зорчих нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна . иймд гарцны уналтуудын зураг төслийг стандартын дагуу төлөвлөлөө .

ГАРЦНЫ УНАЛТЫН ХУЧИЛТ:

Гарцны уналтын хучилтыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний дагуу бетон хучилттай хийхээр төлөвлөлөө. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 30x30x6см хэмжээтэй хөтөч хавтанг ажлын зурагт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.



Зураг №4.



Зураг №5.

1-020
2024 7 4

<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>ЗТ19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ	Үе шат: А/3	
	ЭТСХТ-ийн дарга С.Анхбаяр	Архитектор Саруулмаа АНХБАЯР	Гүйцэтгэсэн С.Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: М1:100	Огноо: 2024.05
	Шалгасан С.Анхбаяр	ТГ Шифр: 6	Зургийн дугаар: 6	Хуудас: 17		

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

БАРИЛГЫН АЖИЛ /ТЕХНИКИЙН ШААРДЛАГА/

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

Явган хүний зам , талбайн барилга угсралтын ажлыг хийхдээ гүйцэтгэгч нь зураг төсөл , техникийн шаардлагыг хангасан барилгын материал , хийц , эдлэл болон тоног төхөөрөмж ашиглан барилгын ажлыг гүйцэтгэнэ .

ЯВГАН ХҮН , ДУГУЙН ЗАМЫН ЧАНАР:

Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад мэргэшсэн инженер техникийн ажилчдыг ажиллуулах нь чухал ба ажилчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамруулсан байх шаардлагатай . тухайн ажлын сонгон шалгаруулалтыг зарлахдаа мэргэжлийн зэргийн нотлох баримт , баталгаажуулалтын талаар урьдчилан тусгаж , мэргэшсэн замчид , ажилчдаар барилгын ажлыг гүйцэтгүүлэх нь явган хүний замын чанар , насжилт , эдийн засагт чухал үр нөлөөтэй .

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ҮЕИЙН МЭДЭЭЛЭХ САМБАР БАЙРЛУУЛАХ:

Явган хүний зам , талбайн томоохон бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө сонин хэвлэл , цахим хуудас , дүүрэг хорооны хурлаар дамжуулан иргэдэд мэдээлэхэд анхаарч ажиллах ба барилгын талбайн эхлэл болон төгсгөл хэсэгт мэдээлэх самбарыг заавал байрлуулна .

ХАМГААЛАЛТЫН ХААЛТ , ХАШИЛТ БАЙРЛУУЛАХ:

Явган хүний зам , талбайн барилга угсралтын ажлыг хамгаалалтын хашилтын дотор гүйцэтгэх ба иргэдийг төөрөгдүүлэхгүйгээр зорчих боломж нөхцөлийг заавал хангах шаардлагатай . явган хүний замын ажил эхлэхээс өмнө хийгдэх ажил болон ажлын үе шат бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж , хамгаалалтын хашилт суурилуулах төлөвлөгөө гаргана .



Зураг №6.

Хамгаалалтын хашилт, түр замын тоноглол (жишээ)

Явган хүний замын өргөн 4000 мм-ээс дээш бол барилгын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх технологийн дагуу хийх ба харин 4000 мм-ээс бага өргөнтэй, түр зам гаргах боломжгүй тохиолдолд авто зам дээр хаалт явган зорчигчдыг чөлөөтэй зорчих нөхцлийг заавал бүрдүүлж өгнө.
Явган хүний замын хучлага байгуулахаас өмнө явган зорчигч барилгын талбайгаар өнгөрөн гарах шаардлага үүсвэл суурийн доод үе, суурийн үеийг сайтар нягтруулсан байх ёстой бөгөөд резинэн зөөлөвчтэй шалавч, модон хавтанг дэвсэж зорчигчийн аюулгүй байдлыг хангана. Түр зам дэвссэн шалавчийг хотын өнгө үзэмжинд нийцсэн халтирдаггүй материалаар хийгдэнэ. Түр зам байгуулаагүй эсвэл ямар нэгэн байдлаар түр замыг шийдээгүй бол захиалагч болон хариуцсан албан тушаалтан ажлыг зогсоох тухай шийдвэр гаргана.



Зураг №7.

БАРИЛГА УГСРАЛТЫН ТАЛБАЙН БЭЛТГЭЛ:

Барилга угсралтын ажлыг талбайд материал , хийц эдлэл хураахдаа хамгаалалтын хашилт барьж нэг цэгт төвлөрүүлнэ . мөн замын хавтан зүсэх ажилбараас үүсэх тоосжилтоос хамгаалах арга хэмжээ авч иргэдийн тав тухыг алдагдуулахгүй байхад анхаарна . барилгын материалыг хураан цэгцлэхдээ гадуур нь хашилт байрлуулж , осол аваар гарахаас сэргийлнэ . Барилга угсралтын ажлын үед орчны бохирдол үүсэхээс сэргийлсэн арга хэмжээг авч ажиллана .

ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХУЧИЛТЫН БҮТЭЭЦ:

Хучилтын бүтээц нь хучлага, суурь болон суурийн доод үеүдээс бүтнэ.

СУУРИЙН ДООД ҮЕИЙН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА: Суурийн доод үеийн материал нь органик бодис , өгөршсөн буюу хэврэг материал , хоёрдагч (шавар) эрдэс бодис , хавтгай буюу хайрслал материал (миканит) , зөөлөн чулуу , тэлэх чадвартай эрдэс бодис , химийн нөлөөнд хялбар өртдөг материал , уусдаг давс зэргийг агуулаагүй байна .

Суурийн доод үеийн материалын ширхэглэлийн бүрэлдэхүүн


Шигшүүрээр өнгөрөх жингийн эзлэх хувь (%)								
50MM	37.5MM	25.0MM	19.0MM	9.5MM	4.75MM	2.00MM	0.425MM	0.075MM
100	90~100	80~100	60~90	30~65	25~55	15~40	8~20	2~8

Замын зохицуулагч:

Явган хүний замын ажил хийх үед түр зам байгуулах шаардлагатай талбайд иргэдийн зорчих нөхцлийг хангах зорилгоор замын зохицуулагчийг ажилуулна. Зам барилгын ажлын явцад түр замын урт 10000 мм - 30000 мм хооронд байвал замын зохицуулагчийн 1хүн/өдөр, 30000 мм-ээс их бол замын зохицуулагчийг 2хүн/өдөр буюу замын хоёр талд байрлуулж ажиллуулна. Замын зохицуулагчийн ажлын хувцас хэрэглэлд шар хантааз, ажлын үнэмлэх, хамгаалалтын малгай, гутал, цагаан бээлий, дохиур мод, шүгэл багтана.

Явган хүний түр зам байгуулах:

Явган хүний зам, талбайн барилгын ажлыг хийж гүйцэтгэх явууд явган зоригчдын ая тух, аюулгүй байдлын үүднээс заавал түр явган зам байгуулна. Барилгын ажлын үед түр зам гаргах боломжийг бэлтгэх ажлын үед судалж, орон зай хангалттай тохиолдолд шинээр барих болон шинэчлэх явган хүний замын хажуу талд түр замыг гаргана.



<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж		
	НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Г.Батбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24
Гүйцэтгэсэн	Г.Батбаяр	Масштаб: М1:100	
Шалгасан	С. Анхбаяр	ТГ Шифр: 7	
		Зургийн дугаар: 7	
		Огноо: 2024.05	
		Хуудас: 17	
		Үе шат: А/З	

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

БАРИЛГЫН АЖИЛ /ТЕХНИКИЙН ШААРДЛАГА/

НЯГТРУУЛАЛТ:

Суурийн доод үеийн хуурай үеийн хамгийн их нягт 90% -иас дээш байхаар жигд нягтруулна. Нягтруулах үеийн чийгийг агууламжийн хүлцэх алдаа $\pm 2\%$ байна. Нягтруулалтын үеийн зузааныг 150 мм байхаар тарааж, гадна талаас дотогшоо чиглэлд нягтруулалтыг гүйцэтгэнэ. Ус зайлуулах байгууламж болон үзлэгийн худаг зэрэг зам дээрх байгууламж орчмын хөрсийг нягтруулахдаа тухайн бүтээцийг эвдэрч гэмтэхгүй хөдлөхгүй байхад анхаарна. Нягтруулагч машин талбай руу орох боломжгүй үед булт индүү, доргиурт гар нягтруулагч эсвэл гараар нягтруулах аргыг хэрэглэнэ.



Зураг №8.

Нягтруулалтыг 500 м² тутамд багадаа нэгээс доошгүй удаа талбайн туршилт хийж дүгнэлт гаргана.

СУУРИЙН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Явган хүний замын барилгын ажлын дараа хавтанд суулт үүсэх хагарах зэрэг асуудал нь янз бүрийн шалтгааны улмаас үүсдэг боловч ихэвчлэн суурийн үед ашиглаж буй материалын ширхэглэл болон нягтруулалттай холбоотой байдаг.

Суурийн үеийн ширхэглэлийн бүрэлдэхүүн Шигшүүрээр өнгөрөх жингийн эзлэх хувь (%)

50MM	37.5MM	25.0MM	19.0MM	9.5MM	4.75MM	2.00MM	0.425MM	0.075MM
100	90~100	80~100	60~90	30~65	25~55	15~40	8~20	2~8

ЦЕМЕНТЭЭР БЭХЖҮҮЛСЭН ЭЛСЭН ДЭВСГЭР ҮЕ ДЭЭР ЯВГАН ХҮНИЙ ЗАМ БАРИХ

Явган хүний зам болон талбайд ирэх ачаалал харьцангуй бага тохиолдолд явган хүний замын чулуун ба бетон хавтанг 2%-ийн цементээр бэхжүүлсэн элсэн дэвсгэр үе дээр суулгах ба дараах аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

ЦЕМЕНТ

Цемент нь ердийн буюу портланд цемент байх бөгөөд AASHTO M-85-07, MNS 974:99 болон бусад олон улсын стандартуудын шаардлагад нийцсэн байна. Цементийн орцыг 1м²-д 2кг цемент байхаар тараана.

СУУРИЙГ БЭЛТГЭХ:

Урьдчилан бэлтгэсэн талбайд элсийг 100 мм зузаантайгаар дэвсэж, элсийг зохих багаж хэрэгслийн тусламжтайгаар, налуу ба түвшинг хангах хэмжээнд сайтар тарааж тэгшилнэ. Тэгшилсэн үеийг 1 м 2-д 10 л -ээс доошгүй усыг жигд цацаж услан, гар доргиулагчаар сайтар нягтруулна.

ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХАШЛАГА СУУЛГАХ

Хашлаганы суурийн нүхийг зохих өргөн, гүнд ухаж нягтруулан, ажлын зурагт заасан маркын бетон зуурмаг ашиглан дэвсгэр үе хийж, хашлагыг нэг талаас нь эхлэн суурилуулж, ар хананы манаасыг хийнэ.

НЯГТРУУЛАЛТ:

Суурийн үеийг хуурай үеийн хамгийн их нягт 90% -иас дээш байхаар жигд нягтруулж, нягтруулах үеийн чийгийг $\pm 2\%$ түвшинд баримтална. ус зайлуулах байгууламж болон үзлэгийн худаг зэрэг зам дээрх байгууламж орчмын хөрсийг нягтруулахдаа эвдэрч гэмтэхгүй хөдлөхгүй байхад анхаарна. Нягтруулагч машин талбай руу орох боломжгүй үед булт индүү, доргиурт гар нягтруулагч эсвэл гараар нягтруулах аргыг хэрэглэнэ. Инженерээс урьдчилан зөвшөөрөл авахгүй барилгын ажлыг явуулсан тохиолдолд ажлыг дахин гүйцэтгэнэ.



Зураг №9.

ХҮЛЦЭХ АЛДАА:

Гадаргуугийн түвшний хамгийн их зөрүү мм байна ± 15 мм байна.

ЯВГАН ЗАМЫН ХАВТАНТ ХУЧЛАГА:

Хавтант хучлагыг явган хүний замаас гадна авто зам, зогсоолд өргөн ашигладаг. Хавтант хучлагын чанарыг бататгахын тулд хавтан хоорондын зайн хэмжээг баримтлах ба завсраар нь дүүргэх элсний чанар ч мөн адил чухал үүрэгтэй байдаг. Явган хүний замын хучилтын бүтээцийн давхаргуудад ашиглаж буй материал болох хавтан, элс хайрга, зохист ширхэглэлийн бүрэлдэхүүнтэй суурийн материалуудын физик чанарууд нь чухал элемент учраас материал сонголтонд анхаарна.

	Зориулалт	Хавтангийн төрөл	Зузаан	Гулзайлтын бат бэх (МПа)	Шахалтын бат бэх (МПа)
Хавтан	Явган хүний зам, талбайд	Хязгаарлахгүй	≥ 60 мм	5 дээш	20 дээш
	Зогсоолд	Зиг заг болон тоосгон хэлбэртэй	≥ 80 мм		42 дээш

1-020
2024 7 4

<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p>	Улаанбаатар хот, Хан Чул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж		
	НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Н.Мөнхзул	ЕГ Шифр:
Гүйцэтгэгч	С.Анхбаяр	ХТСИ_05/24	Масштаб: M1:100
Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр:	Зургийн дугаар: 8
3Т19-507/10			Огноо: 2024.05
			Хуудас: 17
			Ye шат: A/3

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

Хавтан хоорондын зайг тохируулан , хавтангийн төрлөөс хамааран өрөлтийг зөв хийснээр дээрээс ирэх ачаалал жигд хуваарилагдаж хавтанд эвдрэл үүсэхгүй . Мөн хавтан хоорондын зайг зөв тохируулснаар таягтай болон тэргэнцэртэй иргэд ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлдэг . Явган хүний замын хавтан өрөхөд хоорондын зай нь хавтангийн хэмжээнээс хамаарна .

Хавтан	Хавтан хоорондын зай
Том хавтан	3 мм
Жижиг хавтан	2 мм

ХАВТАНТ ХУЧЛАГЫН ЭЛСЭН ДЭВСГЭР ҮЕ : Явган хүний замын элсэн үе хавтангаас ирэх ачааллыг хуваарилж хавтангийн тэгш байдлыг хангах үүрэг гүйцэтгэдэг . Элсэн үед ашиглах материал гүйцэтгэлийн чанараас шалтгаалж хавтангийн өрөлт овон товонтой жигд биш болдог тул материал гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана .

ЭЛСЭН МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА : Хавтангууд хөдөлгөөнгүй байх чанарыг дээшлүүлэхийн тулд завсарт нь элсээр чигжих , хавтангийн тэгш байдлыг хангаж дээрээс ирэх ачааллыг жигд хуваарилах үүрэг гүйцэтгэдэг .


Элсэн материалд тавих шаардлага		
Ангилал	Ширхэглэлийн хэмжээ	Бусад
Хавтангийн заадсанд ашиглах элс	Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ: 2.5 мм-ээс доош; 0.08 мм-ийн хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ: 10%-с доош;	Элсийг зөвхөн хатааж хэрэглэх
Элсэн үе	Элсний ширхэглэлийн бүрэлдэхүүний хамгийн их хэмжээ: 5.0 мм-ээс доош; 0.08 мм-ийн хэмжээтэй шигшүүрээр өнгөрөх хэмжээ: 5%-с доош;	-

ХАВТАН ХООРОНДЫН ЗААДСЫГ ЭЛСЭЭР ДҮҮРГЭХ ТЕХНОЛОГИ : Хавтангийн заадас дүүргэгч материал болох элсийг нойтон хэлбэрээр ашиглахгүй . заадас дүүргэгч элсийг хавтангийн налуу ирмэгийн доод түвшин хүртэл хийнэ . Суурийн үеийг суултаас хамгаалахын тулд сууринд элсийг жигд тараан дэвсэх ба хөндлөн хэвгий болон замын чигийг тодорхойлж гар аргаар хэвтээ чиглэлд тэгшилгээ хийнэ .




Зураг №10. Элсэн дэвсгэр үеийн гүйцэтгэл

ХАВТАНГИЙН ГАДАРГУУГ НЯГТРУУЛАХ : Явган хүний замын хавтан өрөлтийг хийсний дараа шаардлага хангасан хуурай элсийг хавтан хоорондын зайд чигжин резинэн ултай нягтруулагчаар нягтруулна . Хавтан хоорондыг элсээр чигжих нь хавтан өрөлтийн гүйцэтгэлд чухал үүрэг гүйцэтгэдэг тул элсэн чигжээсийг шаардлагын дагуу хийхгүй бол хавтан хөдөлгөөнд орох , суулт өгөх , эвдрэх шалтгаан болдог учраас дараах байдлаар хийнэ .



Зураг №11.

ХӨНДЛӨН ХЭВГИЙГ ТАЛБАЙ ДЭЭР ГАРГАХ : Явган хүний замын гадаргуун усыг саадгүй урсгах нөхцөлийг хангахын зэрэгцээ явган зорчигчийн тав тухтай орчинг бүрдүүлэхийн тулд хөндлөн хэвгийг 2% -иас доош байхаар гүйцэтгэнэ . Явган хүний замын хөндлөн хэвгийг суурийн доод үеэс эхлэн гаргана . Хэрэв суурийн доод үеэс хэвгийг гаргаагүй элсэн дэвсгэр үе дээр хэвгийг гарган хийвэл явган хүний замд суулт үүсэх аюултай .



Зураг №12.

ХАВТАНГ ӨРӨХ , СУУЛГАХ : Явган хүний замын хавтанг өрөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал , тав тухтай байдлыг хангах зорилгоор тэгш байдал , хавтан хооронд зай завсаргүй байх чанарыг тооцож материалд тавих шаардлага болон барилга угсралтын шаардлагыг мөрдөнө .

1-020
2024 7 4

Улаанбаатар хот, Хан Чул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж			
НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ			
ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ	ЭТСХТ-ийн дарга	С. Анхбаяр	Техникийн шаардлага, Тайлбар бичиг
	Архитектор	С. Анхбаяр	Үе шат: А/3
3Т19-507/10	Гүйцэтгэгч	С. Анхбаяр	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Шалгасан	С. Анхбаяр	Масштаб: М1:100
			Огноо: 2024.05
			ТГ Шифр: 9
			Зургийн дугаар: 9
			Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ


153
VI

Хавтангууд хоорондох зайгүй нягт байх чанарыг хангахын тулд дараах зүйлсийг шалгаж хянасан байна. хавтан суулгахаас өмнө материалын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан лабораторт шинжлүүлнэ. мөн тухайн газарт зориулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн газрыг өөрчилж болохгүй. Учир нь үйлдвэрлэлийн газрыг өөрчилснөөр хавтангийн геометр хэмжээ өөрчлөгдөх сөрөг талтай юм. мөн тухайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг урьдчилан авч уг хавтангийн хэмжээгээр хашлага суулгах өргөний зайг тогтоож, хавтангуудыг өрөхөд өргөдөх болон дутах эрсдлийг тооцно. Явган хүний хавтант хучлагатай хийцэд хавтанг буруу өрснөөс үүдэн эвдрэх магадлал их байдаг тул өрөлтөнд гол анхаарлыг хандуулах нь чухал.


- Хавтанг механик зүсэгчээр өө сэвгүй тайрч, тэгшхэн хийх.
- Жижиг дөрвөлжин хавтан ашиглах
- Үзлэгийн худгийн таг замын хавтантай ижил түвшинд байх
- Заадас 2-3мм хэмжээтэй байх.

ХАШЛАГА СУУЛГАХ.

Замын хашлага суулгахад хэв хашмал угсрах, хашлага хоорондын зай, бетон суурийн цутгалтын үе шат зэргийг анхаарч бэхжилтийн хугацаанд барилгын талбайд хашилт барьж хамгаалан барилгын ажлыг хийнэ. Замын хашлагын хэв хашмалыг угсрахаас өмнө суурийн үеийн нягтруулалтыг шалган, суурийн бетон цутгахдаа замын хашлагыг хөдөлгөөнгүй байхад анхаарна. Замын хашлага суулгахаас өмнө орчныг цэвэрлэх ба барилгын ажлын үед зөөж тээвэрлэх явцад эвдэрсэн хашлагыг ашиглаж болохгүй. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой. Замын хашлага суулгах байршилд чигийн тэгш байдлыг хангаж утас татна. Хашлагын суурийн эхний бетон зуурмагийг зураг төсөлд заасан хэмжээгээр бага багаар дүүргэн хүрээр жигд тарааж дээд талын хэсгийг тэгшилж засна. Бетон цутгахдаа зай завсар гаргахгүйн тулд саваа модоор жигд тараана. Хашлагыг суулгахдаа хоорондын 5-10 мм зайг баримтлах бөгөөд 1 x 2 харьцаатай элс цементэн зуурмагийг хашлага хоорондын завсарт дүүргэнэ. Замын хашлага нь сууриндаа ямар нэгэн хөдөлгөөнгүй суусан байна. Хашлага суулгах ажлын хүлцэх алдаа




Зураг №13.



Зураг №14.

ҮЗЛЭГИЙН ДУГУЙ ХУДАГ, ТРАНШЕЙНЫ НҮХ ОРЧМЫН ХАВТАН ӨРӨЛТ

Үзлэгийн худгийн тагийг замын хавтангийн хээтэй нийцүүлэн хийж болно. Үзлэгийн худаг орчмын хавтанг өрөхөд хавтан худгийн тагтай амлан нийлэх хэрэгтэй. Зайлшгүй шалтгааны улмаас нийлэх боломжгүй үед бетоноор шавах боломжтой бөгөөд энэ үед үзлэгийн худаг төмөр тагтай байвал 100мм-ээс бага, жижиг хавхлагатай байвал 50 мм-ээс бага хэмжээгээр хавтантай өнгө дагуу бетон цутгана.



Зураг №15.



Зураг №16.

Төрөл	Хугацаа алдаа	Шалгах давтамж		Шалгах арга
		Хамрах хүрээ	Шалгах хэмжээ	
Хашлагын шулуун ба алгуур байдлын хэмжээ	±8	100 у/м тутамд	1 цэгт	20 метрийн урттай үтэс татаж хамгийн их үтгийг өмнө
Зөргэлдээ хашлаганы өндрийн зөрүү	±2	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмэжж, хамгийн их үзүүлэлтээр авна
Завсрын өргөн	±3	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмэжж, хамгийн их үзүүлэлтээр авна
Хашлагын өндөршилт	±8	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмэжж, хамгийн их үзүүлэлтээр авна
Гадагш хэмжээ	±10	20 у/м тутамд	1 цэгт	Шугаман метрээр хэмэжж, хамгийн их үзүүлэлтээр авна

Төлөвлөж буй явган зам, дугуйн зам, гарцны уналтын барилгын ажлыг хийхдээ монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм стандарт, зураг төсөл болон явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682 2006-г баримтлан хийнэ үү.

1-020
2024 7 4

<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>ЗТ19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж		
	НЭГДСЭН ТӨЛӨВӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Н.Мөнхзул	Ye шат: A/3
Гүйцэтгэсэн	Батбаяр	БГ Шифр: ХТСИ_05/24	Масштаб: M1:100
Шалгасан	С.Анхбаяр	ТГ Шифр: 10	Огноо: 2024.05
			Хуудас: 17

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

134
VI

ГАРЦНЫ УНАЛТ (РАМП)-ЫН БЕТОН ХУЧИЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

Гарцны уналт буюу рампын бетон хийцийн цутгалтын ажлыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх аргачлалд ороогүй зүйлсийг Захиалагчийн инженертэй газар дээр нь зөвшилцөн гүйцэтгэх ба инженерийн зааварчилгаагаар ажлын аргачлал болон ажлын гүйцэтгэлд өөрчлөлт орж болно.

АЖЛЫН ДАРААЛАЛ :

- Гарцны уналт хийх хэсгийг ухаж бэлтгэх
- Гарцны уналт хийх хэсгийг цэвэрлэх.
- Гарцны хэсгийн суурийн нягтруулалтыг хийх
- Хэв хашмал зангидаж , манаас хийж өгнө.
- Гарцны уналт хийх хэсгийг дахин сайтар цэвэрлэх.
- Ус тусгаарлагч дэвсэж бетон зуурмагийн ус газар нэвчихээс сэргийлэх
- В 30 ангийн бетоноор цутгалт хийнэ.
- Бетон зуурмагийг сайтар чигжиж , цул бетон болгож өгөх
- Бетоны гадаргуун өнгөлгөөг цахилгаан багажаар эсвэл гараар маш сайн хийнэ.
- Гадаргууг барзгаржуулах (Нэгэн жигд шүүрдэх)
- Цутгалт авснаас хойш 3 хоногийн турш усан арчилгаа хийх (Хэт халуун , хуурай уур амьсгалтай өдрүүдэд усан арчилгааг өдөрт 2-3 удаа хийх)
- Бетоны хэв хашмалыг 3 хоногийн дараа авч болно (Бетоны талбайн бат бэх хангагдаагүй нөхцөлд усан арчилгааг 7 хүртэл хоног хийх ба Захиалагчийн инженерийн зааварчилгааны дагуу дараагийн шатны арга хэмжээг авна)

ХЭМЖИЛТ ШАЛГАЛТ :

- Бетон сорьцын шоо авч бат бэхийн туршилт хийнэ .
- Бетон цутгалт авахаас өмнө цэвэрлэгээг сайтар хийсэн болон хэмжээг зураг төслийн дагуу зөв тавьсан эсэхийг шалгана.
- Гарцны уналтын бетонд ан цав гарсан эсэхийг шалгана.
- Цууралт ан , цав гарсан эсэх , өнгөлгөө тэгшилгээг шалгах , гарцны уналтын түвшин зурагт заасны дагуу эсэхийг 2 метрийн рейк дээр тэгш ус барьж шалгана.
- Гарцны уналтыг авто замын зорчих хэсэгтэй нийлэх хэсгийг онцгой анхаарч , тэгш байдлыг сайтар шалгах

АНХААРАХ ЗҮЙЛ :

Гарцны уналтыг авто замын зорчих хэсэгтэй нийлэх хэсгийг онцгойлон анхаарах Халуун, хуурай уур амьсгалтай үед нимгэн хальсан бүрхүүл, усаар шүрших зэрэг аргаар чийгийн ууршилтаас хамгаалахаас гадна цементийн гидратацийг түргэсгэх болон бэхжилтийн процессыг түргэсгэхэд нимгэн полиэтилин бүрхүүл хучаас бичил орчин бүрдүүлэх сайн талтай байдаг.


Стандарт техникийн шаардлагуудын хувьд доорхи товчилсон үгсийг ашиглав:

AASHTO	Америкийн стандарт (Америкийн мужийн зам тээврийн удирдах ажилтнуудын холбоо)
ASTM	Америкийн туршилт шинжилгээ, материалын нийгэмлэг
BS	Британы стандарт
BSCP	Британы стандарт
ISO	Олон улсын стандартчилалын байгууллага

Доор дурьдсан ажлуудын нарийвчилсан техникийн шаардлагыг " Авто зам , замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага " ЗЗБНБД 31-008-2016 нормд заасны дагуу авч хэрэглэх ба энэхүү аргачлалд заагаагүй бусад ажлуудыг дээрх техникийн шаардлага болон бусад холбогдох норм , стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

- БЕТОН ХОЛЬЦНЫ ОРЦЫН НОРМЫГ ТОГТООХ
- БЕТОНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ
- БЕТОНЫГ ХОЛИХ БЕТОН ХОЛЬЦЫГ ТЭЭВЭРЛЭХ
- ШИНЖИЛГЭЭ ХИЙХ
- ШООНЫ ТУРШИЛТ ХҮЧИНТЭЙ БАЙХ
- БЕТОНЫ БАТ БЭХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТУРШИЛТУУД
- БЕТОНЫГ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛӨӨС ХАМГААЛАХ
- БЕТОНЫГ НЯГТРУУЛАХ
- ХЭВЛЭМЭЛ БА ХЭВЛЭМЭЛ БУС ГАДАРГУУН ӨНГӨЛГӨӨ
- ӨТГӨН БА ШИНГЭН ЗУУРМАГ (ЦЕМЕНТИЙН УУСМАЛ БА ЗУУРМАГ)
- БЕТОН ЦУТГАЛТЫН АЖЛЫН БҮРТГЭЛ
- СОГОГТОЙ БЕТОНЫГ ЗАСАХ

1-020
2024 7 4

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Н. Мөнхзул	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Гүйцэтгэсэн	С. Анхбаяр	Масштаб: М1:100
3Т19-507/10	Шалгасан	С. Анхбаяр	Огноо: 2024.05
			Хуудас: 17
			Ye шам: А/3

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

155
VI

1. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА :

Гүйцэтгэгч бетонд ашиглахаар төлөвлөж байгаа материалын тухай бүрэн мэдээллийг Захиалагчийн инженер танилцуулна . Инженер бүх материалыг зөвшөөртөл бетон дэвсэж болохгүй . Нэгэнт Инженерийн зөвшөөрсөн материалыг солих буюу өөр материалаар орлуулж болохгүй . Материалын нарийвчилсан техникийн шаардлагыг " Авто зам , замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага " ЗЗБНБД 31-008-2016 нормоос үзнэ үү .

Материалын нэр	Материалд тавигдах ерөнхий шаардлага
Цемент	Цементбетон хучилтанд хэрэглэгдэх цемент нь AASHTO M 85-11-ийн шаардлагуудыг хангасан , 42.5 МПа маркаас багагүй байна .
Чулуу	Бетон орцонд хэрэглэгдэх чулууг чулуун ордоос гаргаж авсан буталсан чулуу хэрэглэнэ . Чулууны шахалтын бат бэх нь бетоны шахалтын бат бэхээс 1.3 дахин их байна . Бетонд хэрэглэгдэх чулууны хамгийн том хэмжээ нь 20 мм ээс ихгүй байна .
Элс	Цэвэр , хатуу ба бүх байгалийн гаралтай элс , буталсан хайрган элс эсвэл AASHTO M 6-08 стандартад нийцэж байгаа буталсан чулуун элсийг бетон зуурмагт ашиглана .
Ус	Бетон зуурмаг болон арчилгаанд хэрэглэх ус нь тос , хүчил , шүлт , сахар , давс , органик бодис болон бусад сөрөг нөлөөтэй бодис агуулахгүй байна . Ус нь MNS AASHTO T 26:2005/ AASHTO T 26-79 (2008) стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нь шинжилж , Захиалагчийн инженер зөвшөөрвөл усны pH үзүүлэлт 6.0 - 8.5 хооронд байж болно .

2. БЕТОН ХОЛЬЦЫГ ЦУТГАХ

(а) Цутгах зөвшөөрөл Инженер бичгээр зөвшөөрөл өгтөл ямар ч бетоны ажлыг эхэлж болохгүй . Гүйцэтгэгч бетон г цутгах гэж байгаа тухайгаа 24 цагийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ .

Бетон цутгаж эхлэхээс өмнө хэв хашмалаас өмнөх цутгалтаас үлдсэн хольцны үлдэгдэл болон бусад гадны материал хогийг гаргаж хаяна .

Инженер зөвшөөрөл өгсөнөөс хойш 24 цагийн дотор бетон цутгах ажлыг эхлүүлнэ . Хэрэв Гүйцэтгэгч энэ хугацаанд цутгалтыг эхэлж чадахгүй бол Инженерийн зөвшөөрлийг хүчингүйд . тооцож Гүйцэтгэгч дахин зөвшөөрөл авна

(б) Бетон дэвсэх гадаргууг бэлдэх Бетон цутгах нүхийг энэ техникийн шаардлагын дагуу бэлдэнэ . Нүхэнд тогтсон усыг шуудуу татах буюу бусад тохирох аргаар зайлуулна . Гүйцэтгэгч шинээр цутгасан бетон болон түүний бүрэлдхүүн хэсгүүдийг угаагдахаас хамгаална . Ухмалын ёроолоос доош хийгдсэн аливаа ус зайлуулах хоолой буюу нүхийг шаардлагагүй болмогц Инженерийн зөвшөөрсөн аргаар бөглөж шавардсан байна .

Хуучин бетон гадаргууд шинэ бетон цутгахаас өмнө дараахи арчлалтыг хийнэ : Хуучин бетон гадаргууг чулуун материалыг ил гартал нугардаггүй хялгасан шүүрээр угаана . Хуурай , чулуун материал нь ил гарсан гадаргуу дээр шинэ бетон цутгана . Гадаргуу нь цэвэр , хатуу , хуурай ба бат бэх байна . Хэрэв угаах явцад гадаргуун хагаралууд цэвэрлэгдэж ил гарвал тэдгээрийг шавар буюу бетон зуурмагаар дүүргэж бөглөнө . Нэг удаад дүүргэх зуурмагийн хэмжээг гадаргууд бетон дэвсэхэд дүүргэсэн зуурмаг хатаагүй байхаар тааруулна .

(в) Цутгах дараалал Гүйцэтгэгч хэрэв бололцоотой бол бүтээцийн нэг хэсэг дэх босоо элементүүдийн цутгалтын хоорондох хугацааг ижил байлгах арга хэмжээ авна . Энэ хугацаа нь Инженер өөрөөр заагаагүй бол цаг агаарын таатай нөхцөлд 3-7 хоног байна . Хэрэв Инженер бетоны агшилтын улмаас ажлын залгаасыг багасгахыг шаардвал шинэ бетон хольцыг 21 хоног болоогүй гадаргууд дэвсэхгүй . Хэрэв зурагт ажлын залгаас хийхээр үзүүлсэн бол тэдгээрийн өргөн ба урт нь зурагт заасан хугацааг өнгөртөл тэдгээрийг дүүргэж болохгүй .

3. БЕТОНЫГ АРЧЛАХ

Ерөнхий


Бетоныг арчлах нь бэхжих явцад бетон чийгшлээ алдаж хатуурах ба бетоны доторх температурын өөрчлөлтөөс болж дулааны хагарал үүсэх зэргээс хамгаална .

Бетоныг арчлах арга нь бетоныг гэмтээхээргүй байна . Бэхжилт нь дээрх шаардлагыг хангатай үргэлжлэх боловч аль ч тохиолдолд 7 хоногоос багагүй байх ба дээр нь дараагийн бүтээц иртэл үргэлжилнэ .

Бетоны арчлалтыг арчлах ажиллагааг даах чадвартай болтол хатуурсан нөхцөлд эхлэх бөгөөд тасралтгүй буюу нилээд том талбайд цутгаж байгаа бол түрүүчийн цутгалт нь дууссан газраас эхэлж хийнэ .

Шинээр дэвссэн бетон бүрийг энд дурьдсан аргуудын аль нэгээр бетон хуурайшихаас сэргийлж арчилна . Арчлалт хийхээр сонгосон аргаа хэрэглэж амжаагүй байхад бетон хуурайшиж эхэлбэл бетоны гадаргууг гэмтээлгүйгээр ус цацаж чийгтэй байлгана .

Уураар болон туяагаар халаахаас бусад аргаар хүснэгт 3-м өгөгдсөн хугацаанд зогсолтгүй үргэлжлүүлэн арчилна .



<p>ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ</p> <p>3Т19-507/10</p>	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С.Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Н.Мөнхзүл	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Гүйцэтгэсэн	С.Анхбаяр	Масштаб: М1:100
	Шалгасан	С.Анхбаяр	Огноо: 2024.05
			ТГ Шифр: Зургийн дугаар: 12
			Хуудас: 17
			Ye шам: А/3

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

156 VI

Арчлалтын хамгийн бага хугацаа

Table with 4 columns: Cement type, Average temperature, and curing days for 10%, 50%, and 70% hydration.

Цаг агаарын халуун нөхцөлд, Инженер шаардлагатай гэж үзвэл, шингэн мембран буюу газар дээр нь хэвлэх аргуудаар арчлалт хийгдэж байгаа бетонон гадаргууд ус цацаж өгнө.

Инженер зааварласан бол Гүйцэтгэгч, дор дурдсан арчлалтын зарчмаас гадна нарны хурц туяа буюу салхи бетон гадаргууд хүрэхээс сэргийлж нар ба салхины хаалт зэргээр хангана.

БЕТОНЫГ АРЧЛАХ АРГУУД

- Хэв хашлага ашиглах
Бетоны хэв хашмалыг нь авалгүйгээр шаардлагатай хугацааны туршид байлгаж арчилна.
- Усаар арчлах
Бетоны гадаргуу дээр ус тогтоох, усаар шүрших, эсвэл байнга нойтон материалаар хучих замаар гадаргууг үргэлж чийгтэй байлгана.
- Шингэн мембранаар арчлах холимог арга

Гадаргууг зүлгэж өнгөлөх шаардлагатай үед болон ажлын залгаасны гадаргууд шингэн мембраны аргыг хэрэглэж болохгүй. Гэхдээ залгаасан дээр бетон тавихаас өмнө элсэн шүршигчээр мембраныг арилгавал энэ аргыг хэрэглэж болно.

Пигмент агуулсан мембраны уусмалыг хэрэглэхийн өмнө сайтар хольж хутгах ба хэрэглэх явцад хөдөлгөж сэгсэрнэ. Хэрвээ уусмалыг хоёр хувааж шүрших шаардлагатай гэж үзвэл эхний шүршилтийг хийсний дараа 30 минутын дотор хоёр дахь шүршилтийг хийнэ.

Хэрвээ шинэхэн шүршсэн мембраны хальс хангалттай хатаж гүйцээгүй байхад бороо орох буюу арчлалтын явцад хальс ямар нэгэн байдлаар гэмтвэл тухайн газарт дээр дурьдсантай ижил хэмжээгээр шинээр уусмалыг шүршинэ.

- Ус нэвтэрдэггүй материалаар хучих арга
Энэ нь бетоны гадаргуугаас чийг алдагдахаас сэргийлж ус үл нэвтрэх материалаар хучих арга юм. Энэ арга нь чийгийн алдагдлаас сэргийлж чадна гэж Инженер үзсэн тохиолдолд л энэ аргыг хэрэглэнэ.

Гадаргууг хучих үед бетон гадаргуу нойтон байх ёстой. Уг материал нь хангалттай хэмжээний ээр зөрүүлж залгааг -аас доошгүй мм 300-өргөнтэй байх ба материалын зэрэгцээ эгнээнүүдийг цавуутай лент, мастик цавуу буюу бусад зөвшөөрөгдсөн аргаар сайтар битүүлж наагаад гадаргууг нийтэд нь хучина.

Хучлагыг салхинд хийсэхгүй байхаар бэхэлж өгнө. Бетоны бэхжилтийн хугацаа дуусахаас өмнө хучлагын аль нэг хэсэг урагдвал нэн даруй нөхөж засварлана. Ус үл нэвтрүүлэх чанар нь алдагдсан материалыг хучлаганд хэрэглэхгүй.

Бетон цутгах аливаа ажлыг эхлэхээс өмнө Гүйцэтгэгч бэхжүүлэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг Инженерт танилцуулж батлуулна.

4. ХЭВ ХАШМАЛ

Хэв хашмал нь бетоны нүүрэн талд эвдрэл үүсгэлгүйгээр амархан салахаар хийгдсэн байх ба, хэрэв шаардлагатай бол, бетоны нүүр талуудын зөв байрлалыг хангах үүднээс бетоны байрлалыг бага зэрэг өөрчлөх зориулалттай хэрэгслээр тоноглогдсон байна. Хэв хашмалыг угсрахдаа шинэхэн бетоны жингийн үйлчлэлээр бий болох аливаа хөдөлгөөн, хазайлт буюу суулт зэргийг харгалзан үзэх ёстой.

Бетоны нүүрэн талыг Инженерийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд нэгэн жигд бүтэц ба өнгө бүхий гөлгөр гадаргуутай байлгах зорилгоор хэв хашмалыг PCI стандартын B-B дотор заслын 1 ангилалын наамал банз буюу усан онгоцонд хэрэглэдэг B S 1088 стандартын наамал банзаар доторлоно.

Бетоны ил гарах гадаргуугийн хэв хашмалын залгаасууд нь хэрэв өөрөөр заагаагүй бол, хэвтээ ба үргэлжилсэн байх буюу эсвэл нэгэн жигд хээтэй байна, босоо байдлаар тэгш байрлуулагдсан Хийцийн нийт хэсэг бүрт хэвний доторлогооны ижил төрлийн материал хэрэглэнэ.

Хэрвээ хэв хашмал цухуйсан байвал агаарыг гаргаж тэр хэсгийг сайтар нягтруулагдсан бетоноор дүүргэнэ

Handwritten signature and date stamp: 2024 7 4

Project information table including: ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ; Designation: НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ; Date: 2024.05; Scale: M1:100.

ИХ МОНГОЛЫН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ

158 VI

Гүйцэтгэгч бетон цутгаж эхлэхээс өмнө бүх шаантаг ба тохиргооны хэрэгслүүдийг бетон цутгах үед хөдлөхөөс хамгаалж бетоныг цутгах үед тэдгээрийг хөдөлгөөнгүй байлгах талаар байнга хяналт тавьж байна .

Гүйцэтгэгч , хэв хашмал , тулах түр байгууламж болон арматур төмрийг байрлуулсны дараа бетон цутгах гэж байгаагаар бетоны ажил эхлэхээс өмнө 24 цагийн өмнө Инженерт бичгээр мэдэгдэнэ . Гүйцэтгэгч Инженерт ийнхүү мэдэгдэхээс өмнө өөрөө ажил нь энэхүү техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна . Инженер Гүйцэтгэгчид ажил эхлэх зөвшөөрөл бичгээр өгөхөөс нааш бетон цутгах ажлыг эхлэхгүй .

Хэвийг задалж буулгах

Ерөнхий

Гүйцэтгэгч , Инженерийн зөвшөөрлийг бичгээр урьдчилан авахаас нааш хэвийг буулгахгүй . Хэвийг буулгах хугацааг тухайн хийцийн байршил ба төрөл , цаг агаарын нөхцөл , бетон хольцонд орсон материал болон бетоны бат бэхэд нөлөөлж болох бусад хүчин зүйлүүдийг харгалзан тогтооно .

Хэвийг бетоныг цохиж хөндөлгүйгээр болгоомжтой буулгана . Бетон нь хэвийг буулгах үед бетонд ирж болох аливаа ачааллыг даах хэмжээний хангалттай бат бэхтэй болтол хэвийг салгахгүй . Бетонд хэт их ачаалал өгөх эсвэл гадаргууг гэмтээж болох аргаар хэвийг буулгаж болохгүй . Хийц нь жигд , аажмаар өөрийн жингийн ачааллаа авах боломжтой байдлаар тулгууруудыг буулгана .

Салгах хугацаа Бетоныг цутгаж дуусах ба хэв хашмалыг буулгах хоёрын хооронд өнгөрөх хамгийн бага хугацаа 0° C - 25° C хэмийн орчны температурт ямар байхыг хүснэгт 4-т өгөв . Дээрхээс бага температурт буюу энгийн буюу сульфатад тэсвэртэй портланд цементээс бусад төрлийн цемент хэрэглэж байгаа бол Инженер өөр хугацаа өгч болно .

Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа (энгийн болон сульфатад тэсвэртэй портланд цемент бетон)

Хэв хашмалын төрөл	Орчны дундаж температур					
	Хэвтэй нь байлгах хамгийн бага хугацаа					
	25° C	20° C	15° C	10° C	5° C	0° C
Гарцны уналтын хэвтээ хавтгай хэв хашмал	3 хоног	3 хоног	4 хоног	5 хоног	7 хоног	10 хоног

Бетоноос авсан шоог эх бетонтой ижил арчилж бэхжүүлсэний дараа шооны бат бэх хүснэгт 5-т өгөгдсөн бат бэхтэй болсон хойно хэв хашмал ба түр байгууламжийг буулгаж болно .

Хэв хашмалыг салгахаас өмнөх бетон шооны бат бэх

(Энгийн болон сульфатад тэсвэртэй портланд цемент бетон)

Түр байгууламж ба хэв хашмалын төрөл	Хэвийг буулгахаас өмнөх шооны 28 хоногийн бат бэх % 35
Гарцны уналтын хэвтээ хавтгай хэв хашмал	

Эдгээр шаардлагыг биелүүлэх нь Гүйцэтгэгчийг бетоныг гэмтээлгүйгээр хэв хашмалыг хугацаанд нь салгах хариуцлагаас чөлөөлөхгүй .

Хэв хашмалыг буулгасны дараа дараагийн ажилд хэрэглэгдэхгүй бетоны нүүрэнд байгаа эрэг чагтны нүхнүүдийг хольцоор сайтар бөглөж өнгөлнө .

Хязгаарлалт

Дор дурьдсанаас бусад хэв хашмалыг буулгана . Үүнд : хэв хашмалыг нь салгавал бусад хэсгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй суурийн хэв хашмалууд , хүрч болохооргүй хаалттай хэсгүүдийн хэв хашмал .

5.ТАЛБАЙН ТУРШИЛТ


Бетон хольцны орцын нормыг Инженер баталсны дараа бетоны зэрэглэл тус бүрээр туршилтын хольцыг хийхээр бэлдэнэ .

Гүйцэтгэгч талбайн туршилтыг барилгын ажилд ашиглахаар төлөвлөж байгаа завод дээр гурван удаа зууралт хийхээр зөвшөөрөгдсөн материалаа бэлдэнэ . Нэг удаагийн зууралтад орох материалын хэмжээ нь заводын бүрэн хүчин чадлаар ажиллуулахад орох хэмжээтэй ижил байна .

Зууралт тус бүрээс дээж авч дараахи туршинжилгээнүүдийг хийнэ. Үүнд:

- (а) AASHTO T119 стандартын дагуу бетоны суултыг шалгах,
- (б) зууралт бүрээс 6 ширхэг шоо авч BS 1881 дагуу туршилт хийнэ,
- (в) зууралт бүрээс 3 ширхэг дээж авч 7 болон 28 хоног дахь бетоны бат бэхийн туршилт хийнэ,
- (г) бат бэхийн туршилт хийхээс өмнө бүх шооны нягтыг тодорхойлно,
- (д) AASHTO T160 стандартын дагуу тодорхойлсон бетон бэхжсэний дараахи уртын өөрчлөлт 0.05 %-иас ихгүй байна.

Handwritten signature and date: 2024 7 4

 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ЗТ19-507/10	Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 17 дүгээр хороо, Их Монголын гудамж НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ БҮХИЙ ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЗУРАГ ТӨСӨЛ		
	ЭТСХТ-ийн дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА, ТАЙЛБАР БИЧИГ
	Архитектор	Н. Мөнхзул	ЕГ Шифр: ХТСИ_05/24
	Гүйцэтгэсэн	С. Анхбаяр	Масштаб: М1:100
	Шалгасан	С. Анхбаяр	ТГ Шифр: 15
			Зургийн дугаар: 17
			Хуудас: 17
			Ye шам: А/3
			Огноо: 2024.05